



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



ӨВӨЛ, ХАВРЫГ ӨНТЭЙ ДАВЪЯ

МАЛЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

2020 ОН

ӨВӨЛ, ХАВРЫГ ӨНТЭЙ ДАВЪЯ

МАЛЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

2020 он

ӨВӨЛ, ХАВРЫГ ӨНТЭЙ ДАВЪЯ

МАЛЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Эмхэтгэсэн:

Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

“Монгол малчин” мэдээллийн агентлаг ХМХ-д хэвлэв.

2020 он

Цаасны хэмжээ: В5

Хэвлэлийн хуудас: 4 х.х



ГАРЧИГ

МАЛ СҮРЭГ ТАРГАН ТАВТАЙ ЮУ

Осгосон малд үзүүлэх тусламж	6
Дулаан хэвтэр, дундуур идэш	6
Ядарч доройтсон малын арчилгаа	8
Малд нэмэгдэл тэжээлийн хэрэгцээг тооцох, төлөвлөх.	9
Бэлчээрийн ургацыг гараар баримжаалан тооцох аргачлал.	11

ХАНГАЙ ДЭЛХИЙН ХИШИГ БОЛОХ

ХАДЛАН ТЭЖЭЭЛЭЭ САЙТАР НӨӨЦЛӨХ НЬ

Гарын доорх материалаар гар тэжээл бэлтгэцгээе	13
--	----

ЭРҮҮЛ, ЧАНАРТАЙ МАЛ ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ ҮНДЭС

Малын тавлаг байдал.	19
Малыг улиралд нь тохируулан эрчимтэй бордож таргалуулах арга.	20

ЦАГ АГААР ШИНЖИХ УЛАМЖЛАЛТ УХААН

Салхины чиглэлээр цаг агаар шинжих	29
Нар, сар, одон мичдээр цаг агаарын байдлыг шинжих	30
Тэнгэр, үүл, цас борооны шинж байдлаар цаг агаар шинжих.	30

МАЛ МАЛЛАГААНЫ АРГА, ТУРШЛАГААС...

Өвөл, хаврын улиралд 5 хошуу мал маллахад анхаарах зүйлс.	32
Аварга малчдын арга туршлагаас	42

ЭРҮҮЛ МЭНД ЭРХЭМ БАЯН

Эрүүл мэнддээ анхаараарай!	47
Малчны аюулгүй байдал ба эрсдэл.	47
Анхны тусламж хэрхэн үзүүлэх вэ!!!	49

ЭРҮҮЛ МАЛ МОНГОЛЫН БАЯЛАГ

Мал сүргийг зарим өвчин эмгэгээс хамгаалах арга	53
Малын төлийн өвчин	56
Малын өвчин эмгэгийг эмчлэх ардын арга	60



ӨМНӨТГӨЛ



Хэдэн үе, удмаараа мянга, мянган жил нүүдэллэн ирсэн Монголын малчид мал маллагааны арвин баялаг туршлагатай, амьдралын арга ухаантай хөдөлмөрч улс билээ. Тиймдээ ч “малчин хүн мянган мэргэжлийн эзэн...” хэмээдэг. Мал сүрэг бол амьсгалаас бусдыг нь ашиглаж болох гайхамшигт бүтээл хэмээдэг шиг хүмүүн бидний амьдралд мал, малчин хоёр мөнхийн үнэ цэнэ, ач холбогдлоо үл алдах ундардаг баялаг билээ. Тиймээс тэрхүү үнэт баялгаа хамгаалж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь төрийн үүрэг, хариуцлага юм.

Ийм ч учраас төрөөс мал аж ахуйн талаар баримтлах бодлогоо тодорхойлж, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Монгол мал хөтөлбөр”, “Монгол малчин хөтөлбөр”-ийг боловсруулан, хэрэгжүүлж өвөл, хаврыг өнтэй даван туулах шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсэн билээ. Хэдий төр засгаас төрөл бүрийн дэмжлэг үзүүлж, малчид маань ч эрвийх дэрвийхээр хөдөлмөрлөж байгаа боловч хэлж ирдэггүй, хийсч ирдэг байгаль цаг уурын хүндрэл, ган, зудыг бид хамтын хүчээр даван туулахаас өөр аргагүй байдалд ордог.

Эдгээр цагийн хүндрэлд урьдчилан бэлтгэлээ хангах, цаг уурын бэрхшээлийг даван туулах, таван хошуу мал тус бүрийг байгаль, цаг уур, бэлчээр нутгийн онцлогтой нь хэрхэн тохируулж маллах аргыг мал ахуйн шилдэг эрдэмтэн, судлаачид, ахлах мэргэжилтнүүд, хашир туршлагатай аварга малчдын арга туршлага, зөвлөмж, зааврыг багтаан гарын авлага болгож Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас эрхлэн та бүхэнд хүргэж байна.

Эрхэм малчид, иргэд та бүхэнд бидний бэлтгэсэн гарын авлага бага ч гэсэн тус дэм болж, өвөл хаврыг өнтэй давна гэдэгт итгэлтэй байна.

Малын цагаан буян малчин таныг өнөд ивээх болтугай...

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн сайд

З.МЭНДСАЙХАН

I БҮЛЭГ

МАЛ СҮРЭГ
ТАРГАН ТАВТАЙ ЮУ



ОСГОСОН МАЛД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ

Осгосон, дарагдсан малыг юуны өмнө нэмнэж, илүү, гэр дулаан байранд оруулвал хурдан сэхдэг бөгөөд бууц ухах юм уу, эрэг жалганы хуурай шороо, элсээр толгойг нь ил гаргаад булаж хучна. Дулаацаж сэхсэний дараа нь тостой хар цай, зутан өгч амны зуурааг гаргана. Мөн битүү хучиж өөрийн амьсгаанд нь дулаацуулж сэхээхээс гадна аагтай хар цай буцалгаж халуун уураар нь утдаг. Осгож, бээрсэн төл малыг гэнэт салхи сөргөөж элгэнд нь салхи оруулж болохгүй. Эхэд нь түргэн сайн хөхүүлбэл амархан сэргэдэг. Осгож, дарагдсан мал дулаан шингэнээ ихээр алддаг тул сахар, давсаар амт оруулсан бүлээн хар цай, ургамлын ханд, хиймэл шүүс зэргийг баг багаар өгч болно.




ДУЛААН ХЭВТЭР, ДУНДУУР ИДЭШ

Салхинаас нөмөрлөгдсөн, нарны гэрэл дулаан илүү их авах боломжтой, цас хунгарлаж тогтоогүй газрыг малчид олж, өвөлжөө бууц сонгож, салхин тал нь богийн нурууг сайн халхлах хэмээний өндөр, газрын доод буюу нар тусах тал нь намхан, сүүдэр үүсэхгүй хороо барьж бог малаа хотлуулна. Өвөл хот хэвтэр захаасаа хөлдөж эхлэх үеэр малын хотны чигжир хөрзөнг гишгэж, ховхолж хороо барина. Отроор яваа болон богийн хороо хашаагүй газар томоор ховхолсон хөлдүү хөрзөнгөөр хороогоо барина. Ингэхэд хэвтэр нимгэдвэл, хуурай болон нойтон шар өтөг, хөлдүү нунтаг бууц дэвсэж өгвөл зохино. Ер нь өвлийн хугацаанд богийн хот хэвтрийг хоёр удаа ховхолно. Хөрзөн хороо



нь энэ жилийн малын дулаалга, ирэх жил малчны бэлэн түлш болно. Даарсан мал идсэн тэжээлээ тав тухтай хивж боловсруулж чаддаггүй учраас хашаа, хороо дулаан байх хэрэгтэй.

Өвөл өдрийн цагт хэвтрийн сүүдэр хэсгийг хуучин даавуу, хэрэггүй арьс, нэхий зэргээр бүтээгээд нар үзэх хэсгийн бууцыг өглөө хонь, малаа гарсан даруйд хэсэг, хэсэг овоолж бүтээнэ. Овоолсон халуун бууц дотроосоо халж хуурайших, наранд ил гарсан хэвтэр өнгөнөөсөө салхинд эвэрших сайн талтай орой хонио хотлохын өмнө тарааж дэвсэж, малын хашаа байр, хот хэвтэрт утаа тавьж, хот хэвтрээ цантах, жавар хургахаас хамгаалдаг аргууд бий. Малын хэвтрийн норсон хэсгийг өдөр бүр цэвэрлэж, хуурай бууц, үнс үртэс дэвсэх нь мал сүргийн туралтыг бууруулдаг. Саравчны урдуур хөшиг татаж, салхи жавраас хамгаалдаг. Хонь байнга хэвтдэг хэсэгт 3-4 нүх ухаж хотны шар бууц, хөлдүү хорголоор дүүргээд дээрээс нь шар бууцаар хучиж хоттой тэгш болгоод 10-12 хоног дарна. Ингэж хатаасан халуун бууцаа ухаж гаргаад хотоо хуурайлна. Энэ бууц хатаах нүх хааш хаашаа 30x40 см хэвтрийг халааж чаддаг тул хэвтрийг хүйтэнд тогтмол дулаан байлгаж чадна. Бууц хатаах нүхийг ээлжийн байлгах нь ашигтай байдаг. Нүхнүүд хашааны хананаас 2-3 метр зайтай байвал зохино. Малыг хэвтэртээ шээхгүй байхад анхаарч, өглөө хот хэвтрээс нь зайлуулж шээлгэх хэрэгтэй. Мөн бог малыг 14 цагаас өмнө усалвал шөнө хэвтэртээ шээхгүй.





■ ЯДАРЧ ДОРОЙТСОН МАЛЫН АРЧИЛГАА:

- Ядрах төлөвтэй болсон үхэр, хонь, ямаа ялангуяа бяруу, төлөг, борлонд цээнийн үндэс, халгайн навч, магмансанзай, хөвөн оройтыг чанаж өтгөн хар цай шиг болгоод уулгаж шаарыг нь идүүлэх хэрэгтэй. Мөн цээнийн үндсийг ногоон хиаг өвстэй (өвсийг хэрчиж) хандлаад уулгахад маш түргэн тэнхэрдэг.
- Ядарсан адууг үхрийн ясаар (чөмөгний булуу бол бүр сайн), үхэр, хонь, ямааг адууны ясаар утах нь маш сайн.
- Хавар тарваганы махаар шаз хийж бага багаар өгөхөд амархан тэнхэрдэг
- Мал сүргээ турааж ядраахгүй байх гол арга бол бэлчээрт байх хугацааг уртасгаж, хужир, усаар дутагдуулахгүй дээд зэргийн тарга хүч авахуулж, тарга хүчийг намар, өвлийн цагт тогтоох нь чухал байдаг.
- Ядарч доройтсон нэг наст малд тарваганы сайн ходоодыг усанд уусган тэжээх нь ашигтай арга мөн. Тарваганы ходоодыг өмнө нь хатаах буюу саванд хийж давсалж хадгалдаг.
- Мөн ядарсан малд тарваганы махыг хатааж чанаад шөлийг өгөх, мөн махыг нь сайн чанаж өгдөг.
- Адуу, тарваганы элгийг хатаагаад нүдэж усанд уусгах юм уу хуурайгаар өгөх нь сайн тэжээл болдог. Энэ нь малыг уургаар хангаж байгаа хэрэг юм.
- Төмс, байцаа, манжин зэрэг хүнсний ногооны навч, цэцгийг сайн хатаагаад хонь ямаа тэжээдэг.
- Агийг сайн хатааж хадгалаад 10 литр усанд 1 кг агь хийж буцалгаад ядруу малд уулгахад амархан тэнхэрдэг.
- Нугын шимтэглээ, хөвөн оройтыг цай мэт чанаж, хужир, давс хийгээд бяруу, ядруу үнээ, бог малд уулгахад тэнхрэхэд нь их дэм болдог.
- Лууль, шарилж, тарваган шийр, цөс өвсийг хольж хивэгтэй багсарч бог мал болон бяруу тэжээхэд сайн.
- Сонгино, сармис, мангирын булцууг өдөрт нэгийг ядарсан төлөг, борлон, бяруунд өгөхөд сайн тэнхэрдэг.
- Хужир, давс, модны нүүрс, ясны гурилыг хивэгтэй хольж мал тэжээхэд эрдэс тэжээлийн дутагдлаас сэргийлдэг хамгийн сайн арга юм.
- Нэг литр буцалсан усанд сахар 50 гр, давс 10 гр хийж уусгаад тахианы өндөг дөрвийг хийж хольж тугалд 250 гр-аар өдөрт 2 удаа, хурга, ишгэнд 25 гр-аар өдөрт 1 удаа уулгахад сэнсрэлт тураалаас сайн хамгаалдаг.
- Нэг литр усанд 200-260 гр аарц, 50 гр гурил, 10гр давс хийж самарч буцалгаж хивэгтэй 1:9-өөр багсарч өгнө. Амаар нь угжих, уулгах аргаар хурга, ишгийг тэжээхэд сайн үр дүнтэйгээр барахгүй таргалж ялангуяа



хурга хурдан сүүллэдэг.

- Физиологийн уусмалыг ингэж бэлтгэнэ. Нэг литр усанд 8.5-9 гр давс хийнэ. Тугалд 300-350 гр, хурга, ишгэнд 100-250 гр-аар өгдөг. Ядарч доройтсон, чацга алдаж шингэнээ барсан төлд буюу усны дутагдал болсон том малд өгөхөд ашигтай байдаг.
- Нэг литр усанд няцалж нүдэж нунтагласан шар будаа 100-150 гр, давс 5-10 гр хийж хурга, ишгэнд уулгаж, сэнхрэхээс сэргийлэх, жилбэгүй төллөсөн хонь, ямааг жилбэ, сүү оруулахад онцгой сайн тустай.
- Ус 10 литр, сүү 500 гр хийж сүүгээ сайн найрч уусгасны дараа 100 гр гурил хийж найруулан уусгаад 5-10 гр давс, тос, сахар 100-150 гр-ыг нэмж буцалгаж хөргөөд бүлээвтэр болгож хурга, ишгэнд 100-150 граммаар уулгах буюу угжихад сэнсрэлтээс сайн хамгаалж чаддаг.
- Ядарч доройтсон болон сэнсэрсэн, чацга алдсан төл, хурга ишгэнд нэг литр усанд цайны нэг халбага хоолны давс, 8 халбага элсэн чихэр хийж найруулаад 20-30 минут тутамд хагас аяга уулгахад шингэний алдагдлыг нөхөх сайн эмчилгээ болдог.

МАЛД НЭМЭГДЭЛ ТЭЖЭЭЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ТООЦОХ, ТӨЛӨВЛӨХ

Малд өгөх нэмэгдэл тэжээлийн хэмжээ нь тэжээлийн төрөл чанар, улирал, цаг агаарын байдлаас хамаарч янз бүр байх боловч ерөнхий шимт чанар нь малын хоногт идэх тэжээлийн 40-60 %, шингэх уургийн 70-80 %-ийг хангах чадвартай байна. Нэмэгдэл тэжээлд тарга хүч султай хээлтэгч, хээлтүүлэгч, төл мал зэргийг хамруулах ба 11 сарын дунд үеэс эхлэн 90-150 хоног тэжээнэ. Нэмэгдэл тэжээлд:

- ▶ 70-75 хувь сайн чанарын өвс
- ▶ 30-25 хувь нь хүчит тэжээл байж болно.





НЭМЭГДЭЛ ТЭЖЭЭЛИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Малын төрөл	Тэжээх хугацаа	Өвс хоногт, кг	Хүчит тэжээл, кг	Эрдэс, г
Хуц	150	0.5	0.2	8-9
Эм хонь	140	0.5	0.2	8-9
Төлөг	90	0.3	0.2	10
Хурга, ишиг	120-150	0.8	0.2	10
Тугал	160-180	1.2	0.5	20
Унага	90	1.0	1.0	20
Ботго	60	1.0	0.5	25
Бух	150	6.0	2.0	40
Үнээ, Гунж	150	5.0	1.5	40
Өсвөр үхэр	120	3.0	1.0	30
Бяруу	120	1.5	0.5	20
Азарга	120	5.0	3.0	40
Гүү	120	5.0	2.0	40
Даага, шүдлэн	90	3.0	1.2	35
Буур	90	6.0	2.0	45
Ингэ	90	5.0	2.0	40
Тором	60	2.0	1.0	35

ЗАРИМ ТЭЖЭЭЛИЙН ХЭМЖЭЭГ БАРИМЖААЛАН ТООЦОХ АРГАЧЛАЛ

	Хэмжих сав Тэжээл	Нэг шаазанд орох хэмжээ (гр-аар)	1л-ийн цагаан шанаганд хэмжээ (гр-аар)
1	Улаан буудай	218	780
2	Хошуу будаа	153	535
3	Арвай	415	660
4	Шар будаа	268	1040
5	Хивэг	153	505
6	Багсармал	73	210
7	Давс	218	1415
8	Хужир, шүү	248	505

Хэмжих багцаа Тэжээл	Шуудай (кг)	Хормой (кг)	Тэвэр (кг)	Шахаж боосон (кг)	Тэрэг (кг)
Өвс	5.5	2.5	7.0	18.6	161.0
Сүрэл	6.2	2.9	7.5	-	-
Ногоон тэжээл	6.6	3.1	8.2	-	-



БЭЛЧЭЭРИЙН УРГАЦЫГ ГАРААР БАРИМЖААЛАН ТООЦОХ АРГАЧЛАЛ

Малчид бэлчээрийн ургацыг баримжаалан тооцож сурах нь маш чухал бөгөөд бэлчээрийг нөөцийг тодорхойлон, ариг гамтай ашиглах, хамгаалах, хэрэгцээт тэжээлийн нөөцөө тооцож сурахад ач холбогдолтой юм.

Хэрэглэгдэх багаж:

- 40 см- ээс багагүй урттай шугам
- Хулдаасан метр
- 30 x 25 см өргөнтэй төмөр жааз бэлтгэж авна.

Тооцох аргачлал:

Сонгосон бэлчээрт төмөр жаазыг байршуулан доторх ургамлыг 2 см өндөрт хайчилж доод ёроолыг тэнцүүлэн атгаж багцын дундаж өндрийг см-ийн хуваарьтай шугамаар хэмжиж дундаж өндрийг тодорхойлно. Үүний дараа багцын тойргийг хэт чангалалгүй туузан метрээр тойруулан хэмжиж дараах хүснэгт ашиглан “дундаж өндөр”, “багцын тойрог” гэсэн багана, мөрний огтлолцолд байгаа тоогоор бэлчээрийн ургацыг нойтноор жингээр илэрхийлэгдэнэ.

Дундаж өндөр	Багцын тойрог, сум				Ургацын ерөнхий үнэлгээ
	4-5	6-7	8-9	10-12	
3-4	0.3	=	=	=	Нэн тачир
5-6	1.5	3.0	4.4	5.9	Тачир
8-9	3.0	6.0	8.8	12	Тачир
10-12	4.4	7.4	10.4	13.1	Тачирдуу
15	5.9	8.8	12.0	14.8	Намхандуу
18	8.8	14.8	29.6	37	Дунд зэрэг
20	14.8	31	46	59	Өндөрдүү
35	22.2	37	52	66.6	Өндөр
Ургацын нягт	Нэн сийрэг	Сийрэг	Дунд зэрэг	Өтгөн	

Жишээ: Ургамлын дундаж өндөр 6 см, багцын тойрог 5 см байсан гэвэл бэлчээрийн нойтон ургац 1.5 цн болно. Харин нийт бэлчээрийн ургацаа тодорхойлохдоо талбайн хэмжээг тодорхойлсон 1.5 цн ургацаараа үржүүлж олно. Хэрэв бэлчээрийн талбайн хэмжээгээ мэдэхгүй нөхцөлд км-ээр тодорхойлж болох ба 1 км дөрвөлжин талбайд 100 га ноогддог жишгийг үндэс болгон тодорхойлно. Тиймээс танай бэлчээр 5 км урттай 10 км өргөнтэй бол 50 км дөрвөлжин талбай гарна. Иймд 50 км x 100 га = 5000 га болно. Нийт ургац= 5000 га x 1.5 цн =7500 цн.

II БҮЛЭГ

ХАНГАЙ ДЭЛХИЙН ХИШИГ
ХАДЛАН ТЭЖЭЭЛЭЭ САЙТАР
НӨӨЦЛӨХ НЬ



ГАРЫН ДООРХ МАТЕРИАЛААР ГАР ТЭЖЭЭЛ БЭЛТГЭЦГЭЭ



■ ТААНА ХӨМҮҮЛИЙН ЗООДОЙ:

Малчид эрт үеэс эхлэн таана хөмүүлийг ургаж жигдрэх үед нь түүж хэрчиж жижиглэн давс шүүтэй холин багсарч зоодой хийж байсан. Бэлтгэх арга нь түүж цуглуулах, хэрчиж жижиглэх, зоодойлж хатаах, савлах, хадгалах гэсэн дараалалтай.

Түүж бэлтгэхдээ хөрснөөс 3-4 см-ийн өндөртэй тасдан авна. Түүхэд бүтээмж багатай төвөгтэй байдаг тул аль болохоор механикжуулж, бага оврын төхөөрөмж нэвтрүүлэх шаардлагатай. Зоодойг хавтгайдуу гонзгой хэлбэртэй хийх бол хэрчилтийн урт 1-3 см, бөөрөнхий хэлбэртэй хийх бол 0.5-1.0 см байна. Хэрчсэний дараа давс, хужир, хивэг, гурил, аарц, ээдэм зэрэгтэй хольж багсарна. 1 кг таана, хөмүүлд 150-200 г гурил буюу хивэг, 50-60 г аарц, 20-30 г давс, хужрыг сайн хольж багсарна. Аль болохоор хаталтыг түргэсгэх зорилгоор зузаан нь 2 см-аас ихгүй, голч нь 3.5-4.0 см байх нь зохимжтой. Түүж бэлтгэсэн түүхий эдийг сүүдэр газар жижиглэхгүйгээр дэлгэн хатааж нунтаглаж савлаад сэрүүн чийггүй газар хадгална.

Мал тэжээхдээ дангаар нь өгөхийн дээр ханд бэлтгэж өгөх нь ядарч доройтсон мал, төлийг тэнхрүүлэхэд илүү үр дүнтэй байдаг.

■ ТААНЫН ХУРУУД:

Таанын толгойг түүж аваад 500 г-ыг 1 кг аарц, 20 г давстай багсран, 2 см-ээс зузаангүйгээр янз бүрийн хэлбэрт оруулан хэлхэж, дүүжлэн хатаана.



ХАЛГАЙГААР ВИТАМИНТ ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ:

Манай орны зарим нэг цөлөөс бусад бүх нутагт тархац сайтай ургамлын нэг бөгөөд төрөл бүрийн амин дэм, үл орлогдох шүвтэн хүчил, эрдэс бодисоор баялаг төгс чанартай витаминт тэжээл бэлтгэх түүхий эд болно. Халгай 5-р сарын дунд үеэс ургаж, 8-р сарын эцсээр хагдардаг. 6-р сарын сүүлийн 10 хоногоос 7-р сарын дунд үеэр хадахад нэг бутнаас дунджаар 3-5 кг тэжээл бэлтгэж болох бөгөөд ургалтын хугацаанд 2-3 удаа хадаж ашиглах боломжтой.



ХАЛГАЙГААР ШАХМАЛ, ХОРГОЛЖИН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ:

Ургалтын эхний үе шатанд байгаа халгайг хайчилж аваад махны машинаар татаад 1 кг тутамд нь 15-20 гр давс буюу хужир, 100 гр хивэг нэмж багсраад урт, өргөн нь 20 см, зузаан нь 5 см хэмжээ бүхий шахуургаар шахан хэвлэж, сүүдэрт хатаан халгайн шахмал бэлтгэнэ. Мөн халгайг гар хадуур, шимээсгээр хадаж, сүх заазуураар хэрчиж жижиглээд хорголжилно. Өрх айл өдөрт 15-20 кг халгайн хорголжин тэжээл бэлтгэх боломжтой. Хорголжин тэжээл бэлтгэх халгайг 6-р сарын дунд үеэс 7-р сарын дунд үе хүртэл ургаж эхэлж байгаа болон эхний хадалтаар нарийн найлзуур навчийг авсны дараа хэнзэлсэн



халгайг ашиглан чанар сайтай халгайн хорголжин тэжээл бэлтгэх нь ашигтай. Нойтон хорголжин тэжээлийг сүүдэр газар 6-8 цаг хатаагаад 20-25 кг-аар савлаж, хуурай сэрүүн газар хадгална.

■ АГЬ-ТААНЫН ЗООДОЙ БЭЛТГЭХ:

Агийг зун, намар толгойлж гүйцэх үед нь модлог ишгүй хэсгийг нь түүж хатаан өвөл, хаврын хатуу цагт тарга хүч муутай, хээлтэй жилбэггүй төллөсөн малд ханд болон бусад шимт ургамал, нунтаг хужиртай хольж сорс, зоодой бэлтгэн төллөсөн эх малд өгөх ба ханд бэлтгэн бог малд 0,5-1 л, бод малд 2 л, төлд 20-30 гр нунтаг хужиртай хольж бэлтгэсэн тэжээлийг бог малд 300-500 гр, бодод 1-2 кг-аар тусгай онгоц саванд хийж дураар нь идүүлнэ. Түүж бэлтгэсэн агийг сонгины цоор, таана, хөмөл, арвай, буудай, гурил, цайны шаар, давс зэрэгтэй хольж багсран зоодойлж нар салхинд хатаана. Бэлтгэсэн зоодойг төллөсөн малд өдөрт нэг удаа 100-150 гр, төлөг борлонд 50-60 гр өгнө.



■ ДОЛООЦ БЭЛТГЭХ:

Долооцын үндсэн түүхий эд нь үр тариа, хивэг, давс, хужир, шүү, борзон зэрэг байх бөгөөд барьцалдуулагчаар шар, улаан шавар, спирт, пивоны шаар, цемент зэргийг ашиглаж болно. Долооц бэлтгэх түүхий эдийг сайтар цэвэрлэн, жижиглэж нунтаглах шаардлагатай. Түүхий эдийг ус, шар сүү, малын шээсээр зуурч, хувин саванд хийж хэлбэржүүлэн хатааж долооцыг бэлтгэнэ.



ХАЛТАР ХОМООЛТОЙ ХОЛИМОГ ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ:

Намрын сөл өвсний хомоолыг манай малчид халтар хомоол хэмээн нэрлэдэг билээ. Намрын халтар хомоолыг түүж цуглуулаад үйрүүлж хивэг, агь, таана, хөмүүл, мангир болон лууль, шарилж, халгай, хужир, давстай хольж багсран гар тэжээл бэлтгэж болно.

Ингэж бэлтгэсэн холимог тэжээл үхэр, бог малд илүү тохиромжтой бөгөөд өдөрт үхэрт 0.5-1 кг, хонь, ямаанд 200-300 гр, төл малд 100-150 гр-аар өгнө.

МАЛЫН СЭВСЭЭР ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ:

Мал нядалгааны үед их хэмжээний сэвс гардаг. Энэ нь малын гүзээнд дутуу боловсорсон, шингэхэд бэлэн байгаа тэжээл бөгөөд сэвс нь идсэн тэжээлийн уургийн хэмжээнээс 6 дахин их болсон байхын зэрэгцээ сэвсний уургийн 20-30% нь нян болон бүдүүлэг биетний уургаас тогтдог. Энэ утгаараа төгс чанартай тэжээлд тооцогддог.

Сэвсээр хийсэн гар тэжээлийг өдөрт бод малд 1-2 кг, бог малд 500-600 гр, богийн төлд 200 гр хүртэл идүүлнэ.

МАХНЫ ГУРИЛ БЭЛТГЭХ:

Махны гурил бэлтгэхийн тулд чанах үйл явц нь мах ясыг гадар өөх, тосноос хялбар ялгах, элдэв өвчний халдварыг устгах, хадгалалт даах чадварыг нь нэмэгдүүлдэг давуу талтай. Махны гурилыг дангаар болон бусад тэжээлтэй хольж мал тэжээнэ. Бог малд өдөрт 50-60 гр, төлд 20 гр, бод малд 100-200



гр өгнө. Мөн махны гурилыг чанаж шөл гаргаад өвөл, хавартаа бяруунд 0.5-2 литр, тэмээнд 3-4 литрийг бэлчээрт гаргахаас өмнө өгөх нь илүү тохиромжтой байдаг.



■ ЦУСНЫ ГУРИЛ БЭЛТГЭХ:

Мал амьтны цус нь уураг болон шимт бодисоор баялаг сайн чанарын тэжээл юм. Мал нядалгааны үед цусыг тусгайлан цэвэр саванд авч шингэн байдлаар болон хөлдөөж урь идүүлэх, хатаах, чанах зэргээр бэлтгэн тэжээлд ашиглана. Хөлдөөж урь идүүлэх замаар бэлтгэхдээ цусыг саванд юулж аваад тоос шороо багатай газар тавьж хөлдөөнө. Үүний дараа гадна талаас хатсан хэсгийг хусаж, аажмаар урь идүүлэн цусны гурил бэлтгэнэ.

■ ЭРДСИЙН ХОЛИМОГ ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ:

Малд ургамал, амьтны гаралтай тэжээлээс гадна эрдсийн гаралтай тэжээлүүд болох ясны гурил, давс, хужир, шүү, цэрд зэрэг нь чухал үүрэгтэй бөгөөд бусад тэжээлтэй хольж болон усанд уусгаж өгөхийн зэрэгцээ тусгай онгоц, саванд хийж хотонд байлган дураар идүүлнэ. Эрдсийн гаралтай тэжээлүүдээс давсыг хоногт бог малд 10-15 гр, үхэрт 25-50 гр, адуунд 20-40 гр, тэмээнд 10-100 гр ноогдохоор тооцон өгөхөд шимт бодисын шингэцийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бодисын солилцоо, ашиг шимд чухал нөлөө үзүүлдэг.

III БҮЛЭГ

ЭРҮҮЛ, ЧАНАРТАЙ МАЛ ЭДИЙН
ЗАСГИЙН ГОЛ ҮНДЭС



МАЛЫН ТАВЛАГ БАЙДАЛ



Мал амьтныг өсгөн бойжуулах, маллах, хайрлах, нэг газраас нөгөө рүү тууварлан хүргэх, хүнсэндээ хэрэглэх зорилгоор хүмүүнлэг аргаар нядлах, боловсруулах зэрэг мал амьтны тавлаг байдлын талаар эртний соёл уламжлалтай билээ. Малын тавлаг байдал гэдэг нь тэднийг өлсөөж цангаахгүй, бэртэл гэмтэлгүй, өвчингүй, айдас түгшүүргүй байлгах, өөрсдийн зан араншингаа илэрхийлэх орчин нөхцөлийг бүрдүүлэхийг хэлнэ.

- Малыг хэрэгцээтэй тэжээл, цэвэр усаар байнга хангах
- Малыг амьдаар нь тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс зайлсхийх
- Малтай эелдэг зөөлөн харьцах, цахилгаан ташуур гэх мэт хэрэгслэлийг хэрэглэхгүй байх
- Малыг аль болохоор сүрэгтэй нь хамт байлгах
- Малын байр хашаа саравч нь тоо толгойд тохирсон багтаамжтай, мал нэг бүрд хүрэлцэхүйц зай талбайтай байх зэрэг нь мал амьтны тавлаг байдлыг хангана.

МАЛЫГ ЭРЧИМТЭЙ БОРДОЖ ТАРГАЛУУЛАХ АРГА

Энэ нь тэжээлийн боломжтой нөхцөлд малыг өвөл, хаврын улиралд бордож таргалуулан махны гарц, чанарыг нэмэгдүүлэх асуудал юм. Малын зун намар авсан тарга хүчийг ашиглан намар шууд бордож таргалуулах нь үр дүнтэй арга боловч намар мах элбэг, үнэ хямд байдаг тул аж ахуйн хувьд ашиг багатай байдаг. Манай оронд хүн амын махны жилийн хэрэгцээний ихэнхийг хөлдөөж хадгалсан мах буюу борц эзэлж, харин шинэ махны хэрэглээ III-ҮII сард эрс



нэмэгддэг билээ. Махны үнэ өсдөг 4,5,6-р сард онд тарган орсон бог малыг болон үхрийг 15-45 хоног бордох цэгт шахаж бордох аргаар тэжээгээд, хавар дээрх саруудад бойлон, хот суурингийн иргэдийг шинэ махаар хангах боломжтой. Өвөл, хаврын улиралд зах зээлд чанар сайтай шинэ мах нийлүүлэхэд өндөр үнээр амархан борлогдож аж ахуйд ашигтай төдийгүй хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдалд сайнаар нөлөөлнө. Сүүлийн үед худалдан авагчид шинэ мах хүнсэндээ хэрэглэхийг илүүтэй сонирхох боллоо. Иймд өвлийн улиралд малд нэмэгдэл тэжээл өгч жингийн алдагдлыг сааруулахгүй эрчимтэй тэжээж, бордох боломжийг ашиглах хэрэгтэй юм.

Малчин өрхийн орлого нэмэгдэхийн зэрэгцээ ижил махны гарцтай болгоход шаардагдах байгалийн бэлчээрийг тодорхой хэмжээнд багасгах экологийн давуу талтай юм. Мөн газар тариалангийн бүтээгдэхүүнийг газар тариалан, мал аж ахуйн хосолсон үйлдвэрлэлд түлхүү ашиглах замаар дэмжинэ. Малын тарга хүчийг алдагдуулалгүй нэмэгдэл тэжээлтэйгээр онд оруулж хүйтний / өвөл, хавар/ улиралд 40-50 хоног эрчимтэй бордон таргалуулж махны эрэлт хэрэгцээ их, үнэ өндөр үед борлуулах нь аж ахуйн хувьд ашигтай төдийгүй, хэрэглэгчдэд амт чанар сайтай, шинэ тарган мах нийлүүлж байгаагаараа илүү ач холбогдолтой юм.

БОРДОХ МАЛЫН ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ, ХЭРЭГЛЭХ АРГА

Төрөл бүрийн тэжээлийг малд өгөхдөө идэмж, шингэцийг сайжруулахын тулд механик, хими, биологийн аргаар зохих боловсруулалт хийнэ. Бүдүүн тэжээлийг хэрчих, дэвтээх, үр тариаг няцлах, нунтаглах, утах, дэвтээж исгэх, шүүст тэжээлийг хэрчиж, жижиглэх, даршлах, бүх төрлийн тэжээлийг хольж багсрах, хорголжлохоос гадна бактериар баяжуулан мал тэжээх нь үр дүнтэй. Мал тэжээх бордох үед төрөл бүрийн тэжээлийн онцлогт тохирсон сараалж, тэвш, хувин сав ашиглан арвич хямгач хандах хэрэгтэй. Тэжээлийн амт чанарыг сайжруулах зорилгоор хүчит тэжээлийг урьдчилан исгэнэ. Хөрөнгөөр исгэсэн тэжээл, уураг, аминдэм, чихэрлэгээр баялаг болно. Хүчит тэжээлийг малд өгөхийн өмнө чийглэх, исгэх зэргээр урьдчилан боловсруулалт хийх хэрэгтэй. Хүчит тэжээлийг малд хуурайгаар өгөхөд хаягдал их гарахаас гадна малын амьсгалын замын зарим өвчин үүсгэх нөхцөл бүрдүүлдэг муу талтай. Иймд заавал чийглэж өгөх хэрэгтэй. Хүчит тэжээлийг /хорголжин, багсармал хивэг, няцалсан арвай, улаан буудай гэх мэт/ исгэхдээ 4 шанага /4 кг/ хүчит тэжээлд буцлам халуун ус нэг литр ногдохоор хийж, дээр нь 4 хоолны халбага тэжээлийн хөрөнгө /дрож/-ийг нэмж, битүү хучаад дулаан газар 6-9 цаг байлгахад исэж мал тэжээхэд бэлэн болно. Хөрөнгөөр исгэсэн тэжээлийг 24 цагаас илүү хадгалж болохгүй.



БОРДОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Өсвөр, залуу малын бие махбодод бодисын солилцоо хамгийн эрчимтэй явагддагаас жингээ богино хугацаанд нэмдэг онцлогтой тул хөдөлмөр, зардал хэмнэх сайн талтай. Өсвөр мал бордоход тарга хүч авалтаас гадна биеийн биологийн өсөлт давхар явагддаг. Бордох мал нь өсвөр насны эрүүл аль болох ижил нас хүйснийх байх тохиромжтой. Хэт турж эцсэн мал бордоо авах чадваргүйн дээр хөдөлмөр, тэжээлийн үргүй зардал гаргахад хүргэнэ.

Бордох хугацаа Бордох малын насыг тарга хүчээс хамааруулан сонгоно. Малыг аль болох өсвөр насанд нь бордвол зардал бага гарна. Малыг намар буюу хавар бордож болно. Тэжээл, хашаа байрны хангамж сайтай нөхцөлд өвлийн эхэн сар цагаан сарын өмнөх 30 хоногийн хугацаанд тарга хүч тогтоох тэжээллэгт байлгаж цаашид сар орчим шахаж бордох, эсвэл 2,3-р сар хүртэл нэмэгдэл тэжээлтэй байлгасны дараа хавар 40-60 хоног шахаж бордох хэрэгтэй.

Нэмэгдэл тэжээлтэй байх үед нэг үхэрт хоногт дунджаар 5 кг өвс, 0,3 кг хүчит тэжээл өгнө.

Бордох хугацааг дараах байдлаар баримжаална:

- тэжээлд бүрэн дасаж жин нэмж эхлэх үе 10-15 хоног
- тарга хүч эрчимтэй нэмэх үе 15-30 хоног
- төгсгөлийн 10-15 хоног тус тус үргэлжилнэ.

Бордох хугацааг сонгохдоо юуны өмнө мал даарахгүй болох үе буюу 2-3-р сард эхлэх, бизнесийн ач холбогдлыг тооцох, аж ахуйн дотоодод хэзээ хэрэглэх зэргээс хамаарна. Хавар ногоо ургах үеийг давхцуулан хэт оройтуулж мал



бордох нь эдийн засгийн хувьд ашиггүй. Тэжээлийн жорд орж буй тэжээл чанар сайтай бол бүдүүн-хүчит багсармал тэжээлийн хэв жор илүү тохиромжтой. Эрчимтэй шахаж бордох аргын гол зорилго нь хоногийн нэмэгдэл жинг хамгийн их байлгахад оршино. Ийм махны гарц, чанарыг сайжруулах үүднээс энерги, шимт бодисоор хангалуун, хялбар шингэх чанар сайтай тэжээлээр хангана.

Тэжээлийн төрөл нь орон нутагт олдоцтой, аль болох хямд байвал зохино. Төрөл бүрийн өвс, тэжээлийн шимт чанар, шингэц нь бэлтгэсэн арга, тухайн жилийн байгаль, цаг уур, байгалийн бүс бүслүүрээс хамаарч өөр өөр байх тул жил бүр бэлтгэсэн өвс, тэжээлийн шимт чанарыг тэжээл үнэлгээний лабораториор тодорхойлуулах шаардлагатай.

Өглөө эрт малд хүчит, холимог тэжээлийг дулаан байранд нь тавьж өгнө. Өвс болон бүлээн усыг нарлагааны хашаанд бэлэн байлгаж өдрийн турш тодорхой хэмжээгээр өгнө. Дан бэлчээрийн маллагаанд байгаа хивэгч малд тухайн идэж байсан бэлчээрийн ургамлын шимт бодисыг боловсруулахад зохицсон хоол боловсруулах өвөрмөц шүүс нийлэгждэг. Хивэгч малын идэж байгаа тэжээлийн төрөл бүрт тодорхой хэмжээний шүүрэл ялгардаг. Хивэгч малыг тэжээллэгийн нэг жороос нөгөөд шилжүүлэхэд гүзээ, болон угтвар ходоодны /ходоод, сайн муу сархинаг/ бичил биетний төрөл, хэмжээ өөрчлөгддөг байна.



Иймд хивэгч малыг бэлчээрийн маллагаанаас байран тэжээлийн өөрөөр хэлбэл, шахаж бордох үеийн тэжээллэгт шилжүүлэхдээ алгуур аажмаар дасгах зарчмыг баримталбал зохино. Бордох малд тэжээлийг эхлээд бага багаар өгч аажим дасгаад цаашид өгөх хэмжээг нэмэгдүүлсээр нормд хүргэх хэрэгтэй. Хивэгч малын хоол боловсруулах булчирхайн үйл ажиллагаанд төрөл бүрийн тэжээлийн өгөх дараалал, тэжээх тоо чухал ач холбогдолтой. Бордож байгаа малд эхлээд баг хэмжээний исгэсэн үр тариа буюу хивэг өгсний



дараа бүдүүн тэжээлээр буюу сайн чанарын ногоон өвсөөр тэжээхэд түүний тэжээл идэх дуршил нэмэгдэж, бүдүүн тэжээлийн идэмж сайжрахын сацуу тэжээл боловсруулах шүүрэл болон исгэгийн нийлэгжилт эрчимждэг байна. Бордох малын хэвтэр байнга хуурай, дулаан байх хэрэгтэй.

■ ӨВӨЛ, ХАВРЫН УЛИРАЛД ҮХЭР БОРДОХ АРГА

Мал сүргийн тэжээл, тэжээллэгийн нөхцөл өөрчлөгдөж нэг улирал, эсвэл нэг хэв шинжээс нөгөөд шилжиж явцад гүзээн дэх бичил болон эгэл биетний тоо хэмжээ, рН, мөн тэжээлийн шингэц эрс өөрчлөгддөг. Ийм учраас бордох үндсэн тэжээлд аажмаар дасгаж тэжээх хэрэгтэй. Бүдүүн тэжээл дээр хүчит багсармал тэжээлийг нормын 1/4, 2/4, 3/4, 4/0 гэх мэт нэмсээр 10-15 хоногт үндсэн хэмжээнд хүргэнэ. Хүчит тэжээл өгөөд тэр дор нь усалснаас малын гэдэс дүүрдэг учир усалсны дараа хүчит тэжээлээр тэжээнэ. Хоногт өгөх тэжээлийг хүчит-шүүст-бүдүүн эсвэл хүчит ба бүдүүн гэсэн дарааллаар гурван удаа тэжээвэл зохино. Мал бордох үед унд ус, давс хужир байнга бэлэн байх шаардлагатай. Бордолт эхлэхээс 15-20 хоногийн өмнө альбендазол, верматонин уусмалын аль нэгээр гэдэсний туузах хорхойг туулгах эсвэл эвомик тариваас үр дүнтэй. Бордож буй үхэр малын хөдөлгөөнийг аль болох хязгаарлах шаардлагатай. Бордож байгаа малд хужир, давс тогтмол өгөх нь тэжээлийн шингэц, тэжээл боловсруулах үйл ажиллагааг сайжруулна. Иймд тэжээлийн хашаанд эрдэс тэжээл /хужир, давс/ байнга байлгана. Өсвөр үхрийн амьдын жингийн нэмэгдэл нас гүйцсэн үхрийнхийг бодвол илүү эрчимтэй байдаг.

Үхэр

- Үхэр бордох хугацаа: 45 хоног
- Хүчит тэжээл (арвай, хивэг) болон өвс
- Хорголжин тэжээлийн орц (арвай 58%, хивэг 40%, давс 2%)
- Бордохын өмнөх үеийн 30 хоногт өгөх нэмэгдэл өвсний хэмжээ өдөрт 7 кг
- Нэг малд хоногт: өвс 12 кг, хүчит тэжээл 4 кг

■ ӨВЛИЙН УЛИРАЛД ХОНЬ БОРДОХ АРГА

Хонь жингээ алдаж, турах тусам түүний махны чанар, амт эрс буурдаг байна. Бэлчээрийн мал өвөл-хаврын улиралд амьдын жингийнхээ 20-30 хувийг алдаж онд орох бөгөөд түүнийгээ зун-намрын улиралд нөхдөг үндсэн дутагтдалтай буюу эрсдэлтэй талтай. Энэ нь малын ашиг шим буурах, өвчин эмгэгт нэрвэгдэх, турж эцэх улмаар олноор хорогдох шалтгаан болдог. Бэлчээрийн хонинд тухайн бэлчээрийн ургамлын шимт бодис боловсруулахад зохицсон хоол боловсруулах өвөрмөц шүүс нийлэгждэг. Бордож байгаа хонинд эхлээд бага хэмжээний исгэсэн үр тариа буюу хивэг /барда/, дараа нь бүдүүн



тэжээл өгөхөд /сайн чанарын ногоон өвс/ тэжээл идэх дуршил нь нэмэгдэж, бүдүүн тэжээлийн идэмж сайжрахын сацуу тэжээл боловсруулах шүүрэл болон исгэгийн нийлэгжилт эрчимждэг. Бордож байгаа хонины хэвтрийг байнга хуурай, дулаан байлгана. Өвсийг дангаар нь сараалжинд хийж өгөхөөс гадна тэнгэр тогтуун дулаахан өдөр хотны ойролцоо цасан дээр 25-30 метрийн зайтай тарааж тавихад мал чөлөөтэй хөдөлж, идэж дулаацна.



Тэжээлийн амт чанарыг сайжруулах зорилгоор хүчит тэжээлийг урьдчилан исгэнэ. Хөрөнгөөр исгэсэн тэжээл уураг, аминдэм, чихэрлэгээр баялаг байдаг. Бордож байгаа хонинд хужир, давс тогтмол өгөх нь тэжээлийн шингэц, тэжээл боловсруулах үйл ажиллагааг сайжруулна. Иймд тэжээлийн хашаанд эрдэс тэжээл /хужир, давс/ байнга байлгана. Өглөө нар тусмагц исгэсэн хивэг /барда/ бага хэмжээтэй, дараа нь өвсөө тавьж өгнө. Үдийн орчимд усалж исгэсэн хивэг, овьёосны хольц, орой нар жаргах үед дахин өвсөөр тэжээнэ. Өдөрт хоёр удаа тэжээхээр бол өдөрт өгөх өвс, хүчит тэжээлийн аль алиныг хоёр хувааж өгнө. Хүчит тэжээл өгсөн дороо усалвал малын гэдэс дүүрдэг учир усалсны дараа хивэг, овьёосны хольцоо өгнө.

Хонь:

- Хонь бордох хугацаа: 45 хоног
- Хүчит тэжээл (арвай, хивэг) болон өвс
- Хорголжин тэжээлийн орц (арвай 58%, хивэг 40%, давс 2%)
- Бордохын өмнөх үеийн 30 хоногт өгөх нэмэгдэл өвсний хэмжээ хоногт нэг толгойд 2 кг
- Нэг толгойд нэг өдөрт өгөх өвс, тэжээлийн харьцаа: өвс 5 кг, хүчит тэжээл 1.5 кг



МАЛАА ШИНЖИХ АРГА УХААН:

- Сарлаг тал хөндий, нам дор, нөмөр газар бараадан идээшлэх, үхэр бэлчээрт гарахын өмнө их мөөрөх, зуны цагт үнээ тугалдаа хоргодон мөөрөлдөх, морь дахин дахин тургих, ботго бага насны тэмээ тонгочин тоглох, тэмээ жалга энгэр нөмөр газар бараадан хэвтэх, ингэ ботгондоо хоргодон буйлаад байх, хонь, ямаа өглөө бэлчээрт гарахын өмнө дэвхрэх, хөөцөлдөх, мөргөлдөх, эсвэл хашаанаасаа гарах дургүй байх, бэлчээрт гарсан хойноо өвс тасралтгүй идэх, хонь ямааны хамар түгжрэх, шуухинах, үс ноос нь хөвсийн чийглэг нойтон болох, салхи руу харж хэвтэх зэрэг шинжүүд нь цаг агаарын байдал муудах, тэнгэр бүрхэх, бороо цас орох, хүйтрэх, салхи шуурга тавихын дохио.
- Ямаан сүрэг задгай газраар бэлчээрлэх дуртай байх, өглөөгүүр малын хот хэвтэр рүү харахад хонь ямааны олонх нь салхи сөрөн хивж хэвтэх, тэнгэр муухай бүрхэг байлаа ч гэсэн бух урамдах, зэлтэй унага унгалдах, адуу шилгээх, ингэ ботгоо орхиод бэлчээрт гарах, мал бэлчээрт гарахыг яарах, бэлчээрт гарсан хойноо тал тал тийш харж, тайван идээшлэх зэрэг төлөв нь тэнгэр сайхан болохын шинж
- Бороо орохын өмнө хонины ноос зөөлөрч, шулуун болно. Өвлийн эхэн сард хонь, ямаа хот, хэвтрээсээ гарч хэвтээд байвал тэр өвөл нь өнтэй дулаан болно. Намар нядалсан хонины гүзээний үс нь их байвал өвөлдөө их цас орох, хүйтрэх, цаг зутруу болдог гэж малчид ярьдаг.

VI БҮЛЭГ

ЦАГ АГААР ШИНЖИХ
УЛАМЖЛАЛТ УХААН



АМЬДРАЛ, ЭД АХУЙН ЗҮЙЛСЭЭР ШИНЖИХ НЬ :

- Бие нозоорон залхуу хүрч нойрмогловол зуны цагт бороо орохын шинж
- Бие хүндрэн, ууцаар хөшиж, нүд бүрэлзэн, тархи толгой манарах нь тэнгэр эвгүйрхэхийн тэмдэг
- Аргал түлш чийгтвэл хур орохын тэмдэг
- Яндангийн утаа эгц дээшээ хөөрч байвал өдөртөө салхи багатай тогтуун байх, утаа хөөрөхгүй хоргодох буюу хажуу тийшээ хийсч байвал салхи ширүүсч тэнгэр бүрхэж хур орохын шинж.
- Тогоо зуухны хөө шатаж “ямаарвал” шуурч салхилахын тэмдэг.
- Шилтэй усны дээд хэсэгт шилний хананд усны дусал тогтож байвал тэнгэр удалгүй муудах, хэрэв тэнгэр эвгүйдсэн үед шилний ханан дахь усан дусал арилсан бол тэнгэр тогтуун болохын шинж

ГАЗАР ОРНЫ БАЙДАЛ, УРГАМАЛ:

- Шөнө хотгор хөндий газар хүйтэвтэр, дов толгод өндөр газраар дулаавтар байвал маргааш нь тэнгэр тогтуун байна.
- Хавар ногоо гарахтай зэрэгцэн мод навчлах нь зундаа гандахын шинж.
- Өвөл мод шуугиж байвал дулаарахын шинж.
- Бэлчээрийн ургамал эрт хүрэнтэн толгойлбол хатуухан өвөл болно.
- Хазаар өвс их ургавал өвөлдөө цас их унана.
- Хялгана их шивээлбэл ялимгүй цастай өвөлтэй учрахын тэмдэг.
- Голын цахилдаг эрт цэцэглэвэл зундаа гандуу байхын дохио.



- Ургамал гандан шарласны хойно энгэр нөмөр газраар ногоо хэнзлэн ургавал өнтэй өвөл болохын шинж.
- Ойн яргуй хээр тал газар жирээс өндөр иштэй ургах нь өвөл ууландаа яггүй цас орохын шинж.
- Өвсний сөл эрт арилбал хатуухан өвөл болно

УЛИРЛЫН ӨНГӨ:

- Зуны улиралд өдөр нь халуун шөнөдөө хүйтэрвэл гандуу байхын тохио.
- Өвөл цасархаг байвал ирэх зун бороо хур элбэгтэй байхын шинж.
- Өвөл дулаан бол зун нь сэрүүвтэр болно.
- Өвөл голын мөсөн дээгүүр ус халиатвал дулаарахын шинж



- Намар орой улаан дагууригтай /тоостой/ урин салхи баруун зүгээс үлээж цас орох нь тойрог байвал өвөл өн болохын шинж.
- Анхны цас бага унасан газарт өн болох нь элбэг.
- Өвлийн цагт үүлний сүүдэр тод байвал өн болно.
- Халуун намраас хүйтэн бороо, цас элбэг, салхи зүүнээс салхилвал өвөл, хавартаа хатуу байхын шинж
- Зун тэнгэр хаяагаараа нүргэлэх нь хуршихын шинж
- Зун огцом халуун шатвал аадар орох нь олон.
- Зун өглөө нь цэлмэг боловч шүүдэр унахгүй бол үд хирд бороо орно.
- Зун манан буух нь тэнгэр цэлмэхийн, өвөл дулаан өдөр болохын гэрч.
- Хавар, зун, намрын улиралд үдээс хойш тэнгэрт хэсэг, хэсэг үүл гарч



үдшээр сийрвэл дараагийн өдрүүдэд цаг агаар хуурай цэлмэг байна.

- Намрын шөнө үүр цайх үеэр салхи гарч үдийн хэрд ширүүсвэл тэнгэр муудна.



САЛХИНЫ ЧИГЛЭЛЭЭР ЦАГ АГААРЫГ ШИНЖИХ:

- Хавар, зун халз өмнөөс болон баруун өмнөөс салхилваас хур орохын шинж.
- Намар, өвлийн цагт салхилваас ойрдоо тэнгэр онгойж гийхийн шинж.
- Салхи зүүнээс удаан үргэлжилвэл зөөлөн шуурга тавихын шинж.
- Салхины чиглэл нар буруу эргэж өөрчлөгдвөл тэнгэр муухайрахын шинж.
- Намар өвлийн улиралд улаан тоостой урин салхи баруун зүгээс байх бөгөөд цас орох нь бага байвал өн болохын шинж.
- Цагаан сарын шинийн нэгэнд салхилваас хавартаа цастай, өвлийн адаг сарын арван найманд хур орвоос хаврын эхэн сарын шинийн найман хүртэл үргэлжлэхийн шинж.
- Бороо, цас орж байхад зүүн, зүүн хойноос салхитай байвал удаан үргэлжилнэ. Өөр зүгээс салхи ширүүсвэл удахгүй арилна.



■ НАР, САР, ОДОН МИЧДЭЭР ЦАГ АГААРЫН БАЙДЛЫГ ШИНЖИХ:

- Нар тунгалаг тусвал үдэшдээ тэнгэр онгойно.
- Нар эртдээ сайхан байваас тэр өдөртөө сайхан байх,
- Нар урвасхийж шар туяа татваас маргааш их салхилах, үдийн хойно нар үүлэнд халхлагдваас шөнөдөө хуртай.
- Нар, сар хиртвээс хур буухын шинж.
- Мичид зулзагалвал зудгүй өнтэй өвөл болохын шинж.
- Өвлийн од анивалзах нь ихэсвэл шөнө хүйтэн хонохын шинж.
- Бүгчим цочир нар гарвал дуутай ширүүн бороо орно.
- Өвлийн тэргүүн сард сар мичид тохиохын урд тэнгэр муудвал цаашдаа тэнгэр сайхан болохын шинж.

■ ТЭНГЭР, ҮҮЛ, ЦАС БОРООНЫ ШИНЖ БАЙДЛААР ЦАГ АГААР ШИНЖИХ:

- Бараан хар үүл гарч нарыг хааваас даруй хур буух, үүлний завсраар нар тусвал тэнгэр онгойно.
- Бороо орж байхад зүүн, зүүн урд зүгт солонго татвал бороо арилахын шинж.
- Бороо ороод зогссоны дараа үүл хойшоо нүүж байвал дахин бороо орохын шинж.
- Үүл урагшаа нүүж байвал тэнгэр цэлмэхийн шинж.
- Үүл хойш, урагшаа зөрөлдөж нүүвэл цас, бороо орохын шинж.
- Өглөөний манан дээш хөөрч үүл болбол бороо орохын шинж.
- Намрын сүүл сарын шинийн есөнд тэнгэрийн заадас арилаад долоо хоногийн дотор эс гарч ирвэл өвөлдөө өнтэй, долоо хонохоос өмнө гарч ирвэл зудлахын шинж. Өвөл тэнгэрийн заадас арилаад дөрвөөс тав хоногийн дараа гарч ирэхэд цасан шуурга болдог. Цагаан морь, хонь өдөр цасан шуургатай болон бямба гаригт шуурга эхэлвэл цаашид тэнгэр муухайрахын шинж.
- Өвлийн хөх хулгана өдөр хур орвоос их хэмжээний нутагт цас их унаж зудлахын шинж.

V БҮЛЭГ

МАЛ МАЛЛАГААНЫ АРГА
ТУРШЛАГААС...



ҮХЭР СҮРГИЙГ ӨВӨЛ, ХАВАР МАЛЛАХ АРГА ТУРШЛАГА



■ ҮХРИЙН ХАВРЫН МАЛЛАГАА:

Үхрийг аль болохоор урт хугацаагаар идэшлүүлж, бүрэн цатгаж тэнхрүүлэхийг эрхэмлэж, сахлаг өтгөн өвстэй, алсаасаа нөмөр нөөлгөтэй ухаа толгод, уужим хөндий хоолой, уулын бэл хормой зэрэг хад бартаа багатай цагаандуу цас багатай бэлчээрт хариулна. Энэ үед үхэрт борог тун чухал. Ер нь хавар борогт сайн махлуулаагүй үхэр зун тарга гүйцэд авч чадахгүй. Хээлтэй үнээг гуу, жалга бартаа багатай нам дор цагаан газар бэлчээдэг. Хангайд бол хаврын дунд сарын дунд үе, говь тал хээрийн бүсэнд хаврын тэргүүн сарын дундуур өвөлжөөний өтөг бууцнаас гарч хаваржаална. Хаврын хавсаргад үхрийн тарга хүч амархан мууддаг учраас хариулга маллагааг жигд сайн байлгаж, өдөр бүр цатгах хэрэгтэй. Эцэж турсан тугал бяруу, хөгшин, хээлтэй ба тугалласан үнээг хаваржааны ойролцоох нөөц бэлчээрт хариулан өглөө, орой нэмэгдэл тэжээл, ногоон өвс, дарш, багсармал тэжээл өгнө.

Хавсарга, шороон шуургатай хүйтэн өдрүүдэд үхрийг уул нуруу, даваа нугачаа ухаа толгодын ээвэр энгэр, тохойд хариулна. Нутаг бэлчээр хариулга маллагаа нь тохирч байгаа үхрийн өнгө зүс, гэдэс хээл сайн, үс хөөврийн гуужилт түргэн, сүү жилбэ сайтай, бэлчээртээ тогтвортой, төллөсөн үнээ тугаллаг байдаг. Үхэр ногоо хөөж гүйн сульдахаас болгоомжилж, борог, өлөн, ногоон угтай хазаар хиаг, ерхөг бүхий бэлчээрт тогтоож хариулан, ойр, ойрхон хугацаанд бэлчээр сэлгэж, ногоо сайн гарсан үед шууд ногоонд, оруулж түргэн цатгавал амархан тэнхэрнэ. Эр сувай үхрийг алсын соргог бэлчээрт үүрээр



бэлчээж, орой гэгээ тасрах үед хотлуулдаг. Тугалтай үнээг эх сүргээс ялган ойрын соргог бэлчээрт хариулна. Үхрийг өдөр тутам ханатал нь усалж 7 хоногт 2-3 удаа хужирлана.

Арчилгаа маллагаа, нутаг бэлчээр нь тохирч байгаа үхрийн гэдэс хээл сайн, үс ноос сайтай, бэлчих хотлохдоо налгар тайван, бэлчээрт тогтвортой идэшлэх ба баас нь аглуун том, хальс салсгүй байдаг. Үхрийн хаваржааны нутгийг зөв сонгож авах нь төлийн бэлтгэлийн нэг чухал зүйл байдаг. Хавар үхрийг бэлчээрийн алс захаас дотогшлуулах журмаар хариулдаг. Тэгэхдээ салхины дээд талын бэлчээрийг аль болохоор хямгадан, салхины доод талын бэлчээрийг голлож ашигладаг. Тугаллах шахсан үнээ, турж эцсэн тугал бярууг гаднаа үлдээж өвс, хивэг будаа, багсармал, гар тэжээлээр тогтмол хэмжээгээр тодорхой нэг хугацаанд тэжээж, байнга усална. Өвөл тарган орж, хавар эрт тэнхэрсэн үнээний ороо жигд ирж, эрт хээл авна.

■ ҮХРИЙН ӨВЛИЙН МАЛЛАГАА:

Үхрийн алсын хүйтэн салхи, жавар үлээхгүй уулын ам суга, ухаа толгодын эзвэр энгэр, гүн жалга, хонхор хотгор ихтэй дулаан бэлчээрт хариулдаг бөгөөд өлөн, хиаг, борог, ерхөг, хялгана, агь, бутуул, цоорын навч, төрөл бүрийн шарилж, божмог, морин дүрвээ, бут бударгана, цахилдаг, дэрсний салмай, хазаар өвс зэрэг амт чанар сайтай өвс ургамал бүхий бэлчээр тохиромжтой. Намрын сүүлч, өвлийн эхээр өтөг бууцгүй хонд газар хотлуулж байгаад үхрийн баасны өнгө шөнөдөө хөлдөж цантаж эхлэх үеэс өвөлжөөнд буувал зохимжтой. Өвөлжөөнд эрт буувал үхэр бээрэг болдог, нөгөө талаар ойр хавийн бэлчээрийг сорчлон идэх, гишгэж дагтаршуулах зэргээр муутгадаг. Өвлийн улиралд цаг агаар, бэлчээрийн өвс ургамал, нөмөр дулааны байдлыг харгалзан үхрийн бэлчээрийг ерөнхийд нь алсын, ойрын, нөмөр гэж ангилж, тэнгэр цэлмэг, салхи шуургагүй дулаахан байвал алсын задгай цайдам газрын бэлчээрт эр сувай үхрийг, ойрын бэлчээрт хөгшин үнээ, тарга хүч муутай тугал бярууг бэлчээнэ.

Онцын хүйтэн цас шуургатай үед салхины дээд талын өвс сайтай нөмөр бэлчээрт хариулна. Үхэр бол сүргийнхээ дотор хэд хэдээрээ ижилсэн идэшлэж хэвтдэг онцлогтой тул тэр аяыг нь тааруулж дагуулж хариулах хэрэгтэй. Өвлийн цагт үхрээ өглөөний 9 цаг буюу нар нэлээд халсан хойно бэлчээн, орой аясаар нь хотлуулна. Тэгэхдээ өвлийн үхрийг зөөлөн тууж таруун хариулах хэрэгтэй. Өвөл ядарч доройтсон үхрээ дор орохоос нь өмнө эртхэн хивэг, будаа, багсармал, гар тэжээлээр, тогтсон хэмжээгээр байнга таслалгүй тэжээнэ. Тогтмол хугацаанд жигд хэмжээний тэжээл идүүлж сургасан үхэр, бяруу цагийн мууд турах нь байтугай, хүч нэмнэ.



Үхэр цас малтаж өвс олж идэж чаддаггүй мал учраас цасны нимгэн, эрт хайлж цоохортдог газрын бэлчээрийг дагуулан идээшлүүлнэ. Цэлмэг дулаан өдөр үхрээ эрт бэлчээж, алсхан гаргаж хөндий хоолой, ухаа толгод, зоо нурууны ар хаяхын бэлчээрт салхи шуургатай хүйтэн өдөр өглөөний жавар арилсны дараа хотноос гаргаж уул, толгодын энгэр, өвөр, жалга, судаг, хонхор хотгор, дэрс түнгэ зэрэг нөмөр нөөлгөтэй бэлчээрт хариулна.

Үхрийг өглөө бэлчээрийн цаад захад хүргэн аажмаар дотогшлуулах байдлаар бөөндүү тогтоож хариулна. Харин бартаатай газар бэлчээж болохгүй. Үхэр бэлчээртээ даарснаас болж амархан зутардаг тул нөмөр дулаан газар хариулж, хөгшин, хөвөө, туранхай ядруу үхэр тугал бярууг нэмнэж, эврэвч хийх зэргээр хүйтнээс хамгаална. Цас орсон буюу их хүйтэн шөнө үхрийн нуруунд цас цан тогтож, нуруунаас нь хайрч жиндүүлэх учир бэлчээрт гаргахын өмнө арилгаж байх шаардлагатай. Ус бэлчээр хариулга, маллагаа нь тохирч, тарган тавтай өвөлжиж байгаа үхрийн өнгө цариг, гэдэс хээл сайн, зөөлөн намуун хөдөлгөөнтэй, шөнө хэвтрээсээ босож холхихгүй, тайван хэвтэж хивэх бөгөөд баас нь том байдаг. Харин бэлчээр тохироогүй буюу хэт холдож алслагдсан бол өглөө бэлчээхэд хашигнан зогсож, тууж хөдөлгөхөд толгойгоо сэжлэн, сүүлээ шарван хойрго удаан явна.

Үхрийг өглөө бэлчээж гэдэс гаран бие нь дулаацсаны дараа харзны буюу худгийн усаар өдөр 1 удаа усална. Хангайд өвлийн улиралд үхрийг алсын салхи шуурга, жавар багатай, эргэн тойрондоо нөмөр сайтай ээвэр газар маллана. Өвөлжөөнд буух үеэсээ бэлчээрээ хуваарьтай ашиглаж үхрээ эхлээд алсын бэлчээрт хариулж байснаа хүйтний эрч нэмэгдэн, цаг хатуурч, мал турч эхлэх



үед ойрын нөмөр соргог бэлчээрт хариулна. Өвлийн дулаан өдөр үхрээ соргог бэлчээрт идэшлүүлж байгаад үдийн хувьд харзны усаар усална. Харин цасан шуургатай буюу их хүйтэн өдөр усаа бага зэрэг бүлээсгэн, хужир давс нэмж уулгана. Тал хээрийн бүсэнд үхрийн хариулга маллагаа хангайхаас өөр байдаг. монгол үхэр бэлчээр ашиглахын хувьд хонь ямааг бодвол дутуу байдаг учраас аль ч улиралд үхрийн бэлчээрийн нас хүйсэнд нь тохируулан сонгож, нарийн хуваарьтай ашиглана. Хүйтний улиралд бэлчээрийг алсын, ойрын нөөц гэж хуваан, алсын бэлчээрийг салхи жаваргүй цэлмэг дулаан өдрүүдэд, ойрын бэлчээрийг цастай юм уу хүйтэн салхигүй үед ашиглана.

Салхины дээд талын соргог сайхан өвстэй, нөмөр нөөлгөтэй газрын бэлчээрийг зориуд нөөцлөн цасан шамарга, шуургатай онцын хүйтэн өдөр ашигладаг. Үхрийг бага явж цадталаа идэшлэх өвстэй газар маллаж байвал хүч нь буурдаггүй сайн талтай. Өвөл хаврын улиралд үхэр сүргийн нутаг бэлчээр тохироогүй бол толгой сэжлэн, сүүлээ шарван, хойрго удаан хөдөлгөөнтэй болж баас нь жижигрэнэ. Хэрэв нутаг бэлчээр, хариулга маллагаа тохирч байвал өнгө нь цагираг сайтай, баас нь том хивэлт удаан байдаг. Үхрийг дааруулбал амархан зутрах тул хэвтэр бууцыг байнга хуурай дулаан байлгаж, хужраар хангадаг.

Хүйтний улиралд байнгын хужир шүүтэй говь, хөдөө хосолсон бэлчээрт хариулна. 12-р сарын сүүлчээс 3-р сарын эхэн хүртэл бэлчээр нутгийг зөв сонгож ус хужраар тогтмол хангаж, дулаан хэвтэрт хотлуулж, тураалгүй онд оруулсан үхэр хаврын ямар ч шуурга шамарганд зутардаггүй. Үхрийг өглөөд салхи сөргүүлэн бэлчээж нөмөр ээвэр газрыг дагуулан хариулж орой жавраас өмнө ойртуулан хотлуулбал шөнө тайван хэвтэнэ. Их цастай үед бэлчээрийн цас хагалах ,адуу явуулах зэргээр бэлчээр гаргаж байж үхрээ идэшлүүлнэ. Үхрийн хэвтрийг үргэлж хуурай байлгахын тулд өглөө эрт босгож хэвтрээс нь өөр газар шээлгэж, хашаа байранд нь дахин оруулж сургахын зэрэгцээ, хотны хүйдэс хөлдүүсийг өдөр болгон цэвэрлэж тусгай газар хамарлан овоолж дараа жилийн бууц, түлшинд хэрэглэхээр нөөцөлнө.



ТЭМЭЭН СҮРГИЙГ ӨВӨЛ, ХАВАР МАЛЛАХ АРГА, ТУРШЛАГА

■ ТЭМЭЭНИЙ ХАВРЫН ХАРИУЛГА, МАЛЛАГАА:

Хавар цагийн бэлчээрт хонхор, хотгор тойромтой хужир, шүүгээр баялаг, салхины цохилт багатай, нарны ээвэр энгэр газар тохиромжтой. Шар мод, бор бударгана, өргөст харгана, үхэр харгана, багалуур, шаваг, заг, агь, хиаг, хялгана, суль, божмог, тэсэг олон төрөл хамхаг зэрэг хавар эрт нүдэлдэг ургамлуудыг тэмээ дуртай иддэг. Говийн бор бударгана, шаваг, харгана, агь, шар мод зэрэг 2 дугаар сүүлч, 3 дугаар сарын эхээр хамгийн түрүүнд нүдэлдэг ургамлууд нь тэмээг амархан тэнхрүүлдэг. Хаврын хавсарга шуургатай хүйтэн өдөр зэгс, дэрстэй зөөлөн хөрстэй бэлчээрт салхи сөргөн бөөндүү бэлчээнэ. Хаврын тэмээг нэг өнжөөд услаж, хужирлах шаардлагатай байдаг. Бут цэцэглэх 4 дүгээр сараас говиос гарч талдуу газар нутаглана. Хаврын маллагаа нь тэмээг ногоо эрт идүүлж түргэн тэнхрүүлэх, махлуулахад чиглэнэ.



■ ТЭМЭЭНИЙ ХАВРЫН БЭЛЧЭЭР:

Тэмээ бэлчээрт цадаж байгаа эсэхийг хорголоор нь шинждэг. Бүдүүн тэмээ хэвтэртээ шаравтар өнгөтэй, бөөрөнхий хэлбэртэй нэг хормой орчим хоргол гаргаж байвал цадаж байна гэх ба хоргол нь цөөн, гонзгойдуу хэлбэртэй, нэг үзүүр нь шовх, хар цоохор өнгөтэй бол бэлчээрт цадаагүй, турах төлөвтэй гэж үздэг. Бударгана, заггүй уян өвстэй бэлчээрт хавар удаан байвал ноос хөндийрөх муу, бас эцэж зундаа тарга хүч авалт муу байх талтай. Ногоо гарах үеэр шар шаваг их идүүлбэл тэмээ хатиардаг.



■ ТЭМЭЭНИЙ ӨВЛИЙН ХАРИУЛГА, МАЛЛАГАА:

Өвлийн хариулга маллагаа нь тэмээний тарга хүчийг тогтоон барих, ингэ буурыг нийлүүлгэд оруулах, тором, өсвөр тэмээг онд бүрэн оруулахад чиглэнэ. Тэмээ өвөлжүүлэх нутаг намхан уул, толгодтой юмуу уулын энгэр, нөмөр дулаан, говь, хээр хосолсон зөөлөн хөрстэй нам газар тохиромжтой.

Өвлийн улиралд заг, шар мод, бударгана, боролзой, харгана, шавагтай говирхог ба дэрс, цагаалж өвстэй хээрийг ээлжлэн ашиглана. Дан заг, бударганаар голлосон бэлчээрт өвөл үргэлж бэлчээвэл амархан эцэж тарга хүчээ алдана. Цасан шуургатай хүйтэн өдөр уул, хяр, толгодын өвөр бэл завсар, жалга, хөндийгөөр нарны тусгалтай нөмөр газар хариулбал тэмээ даарч бээрэхгүй тайван идээшлэнэ. Өглөө цан хүүрэг арилсан хойно тэмээг бэлчээж, орой нар жаргах үед хураадаг тул өвлийн улиралд тэмээ 8 цаг орчим хугацаагаар бэлчээрлэнэ. Цас ихтэй үед бут, бударгана, борогтой бэлчээрт хариулах бөгөөд хүйтний улиралд тэмээ улаан бор бударгана, хамхуул, борог өвсийг дуртай иддэг, харин хөлдүү бут, мод, бор бударгана тарга тэвээргийг алдуулдаг тал бий. Хүйтний улиралд хэвтэр муугаас тэмээ амархан турдаг тул хэвтрийг үргэлж хуурай дулаан байлгах шаардлагатай.



■ ТЭМЭЭНИЙ ӨВЛИЙН БЭЛЧЭЭР:

Мөн эцэнхий ингэ, торомыг нэмэгдэл тэжээлээр тэжээнэ. Ингэ нийлүүлгийн үед тэмээний нутаг бэлчээр, хэвтрийг сайтар тохируулах нь ингэ, буурны ороо идэвхжилтийг сайн байлгах нэг нөхцөл болдог. Нийлүүлгийн үед заг,



шар мод, багалуур, бударгана, шар цахилдаг, боролзой, лавай, шаваг, лууль, дэрс, бут ургадаг говь бүхий алсын нөмөртэй хонхор, хотгор газар тэмээнд нэн тохиромжтой. Ингийг буурцагт ургамал бүхий бэлчээрт хариулахад хээл авах нь илүү байдаг. Тором, туранхай ингэ, өсвөр тэмээний хэвтэрт багагүй анхаарал тавих хэрэгтэй. Дороосоо жиндэж даарсан тэмээ, ялангуяа тором амархан турна. 11 дүгээр сарын дунд үеэс хөгшин ингэ, торомыг нэмнэх нь чухал.

БОГ МАЛ МАЛЛАХ, АРГА ТУРШЛАГА



Бог малд бэлчээр нутаг сонгон тохируулах, улирлын бэлчээрийн онцлог, анхаарах асуудал:

Монгол орны бэлчээр нь тухайн жилийн хур тунадас, байгаль цаг уурын хэлбэлзлээс хамаарч ургацын бүрэлдэн тогтох хугацаа, тэжээлийн нөөц нь харилцан адилгүй байдаг. Тиймээс бэлчээрийг ашиглахдаа ургац, бүтээмжийн түвшинд малын төрлийг тохируулах нь чухал юм. Хонь, ямааны хариулга тэжээллэгийг тохируулан арчилж малладаг арга барил нутаг нутагт, түүнчлэн хүн хүний араг туршлага нь өвөрмөц хэдий ч бэлчээр сонгож тохируулах, хариулах, ус, хужраар хангах, оторлон тарга хүч авахуулах, түүнийгээ чамбайруулах, тогтоох, нэмэгдэл ба гар тэжээлээр тордож тэнхрүүлэх зэрэг үйл ажиллагаа нийтлэг шинж чанартай байдаг.

Хүйтний улирал: Жавар, салхины цохионоос халхалсан нөөлөгтэй, наранд ээвэр, өглөө оройны нарны тусгал сайтай, цас хөрлөж хунгарладаггүй бэлчээр зохистой.



БОГ МАЛЫН ХАВРЫН МАЛЛАГАА:

Хонь, ямааны хаврын бэлчээр, маллагаа, тэжээллэг өвлийнхтэй ойролцоо. Өвөлжөөнд хавар орой болтол суулгүй, цаг улирлын ая байдлыг харгалзан, нөмөр сайтай, хонд бүхий газар хаваржаалах нь зүйтэй. Өвөлжөөнд хэт орой болтол суух нь хурга, ишиг хачиг хувалзанд баригдаж, амруутах, гэдэс ходоодны болон уушиг, нүдний өвчнөөс өвчлөхийн нэг шалтгаан болдог.



- Хаваржаанд нилээд хугацаагаар сууж, төл бойжуулж хөрөвжүүлэх шаардлагатай байдаг учраас хаваржаа нь урьд жилийн зун, намраас нөөцөлж хадгалсан соргог өвстэй нутаг байвал зохино.
- Хаваржааны бэлчээрийг төллөсөн, хээлтэй, ядарч турсан ямааны гэж зааглан, сар өдрөөр хуваарилж өдрийн хүйтэн, дулаан, салхины байдалд тохируулан, дулаан өдөр тачир өвстэй задгайдуу бэлчээрт, хүйтэн өдөр нөмөр сайтай, модлог ургамал, сахлаг өвстэй бэлчээрт бөөндүү бэлчээх хэрэгтэй.
- Хавар хонь, ямааг өдөр бүр өглөөгүүр бэлчээж идэшлүүлсний дараа үдээс өмнөхөн буюу үдийн үед услах нь тохиромжтой. Хаврын цагт бог малыг усаар хэдийчнээ сайн хангавал идсэн өвс тэжээлийнх нь шингэц сайжирч мал амархан тэнхэрч махлан, жилбэ нь сайжирч төлийн өсөх торниход сайнаар нөлөөлнө.



- Хаврын хатуу улиралд хонин сүргийн бэлчээр, хариулга маллагаа тохирч ус, хужир хангалттай байвал өөг цатгалан байдалтай, бэлчээх ба хотлохдоо удаан нозгой хөдөлгөөнтэй, бэлчээртээ маш тогтвортой, налгар тайван идэшлэж, байн байн хэвтэж босох буюу салхи сөрж явах дуртай болно. Нийт сүргийн өнгө цариг засран сайжирч, тамир суун, цовоо сэргэлэн болж, үс ноос нь хөөрч хөндийрөх нь сайн байна.
- Хаврын урь орж ногоо цухуйх үеэр борог, буйлс, нохой шээрэн, шаваг, загасгал, дэрс, бор бударгана, ээрэм, шарилжны малтууш, сая цухуйсан таана, яргуй, нүдэрсэн агьтай бэлчээрт хариулахад ямаан амархан гэдэслэж тэнхэрнэ. Ямааг хэдий чинээ эрт ногоонд цатгавал махалж таргалах нь сайн бөгөөд сүү сааль нь нэмэгдэнэ.

■ БОГ МАЛЫН ӨВЛИЙН МАЛЛАГАА:

Хонь, ямааны өвлийн маллагаа нь зун, намрын тарга хүчийг тогтоох, хүйтэн сэрүүнд сойж тэсвэртэй болгон өлчиржүүлэх, өвс бэлчээрийг ариг гамтай ашиглах, ширвэгдэж ядрах хандлагатай хонь, ямааг нэмэгдэл ба гар тэжээлээр тэжээх, хээл хамгаалах зэргээр онд цариг сайтай оруулахад чиглэгдэнэ.



- Малчдын уламжлалт туршлагаас үзэхэд өвлийн улиралд алсын хүчтэй салхи жавар хаах нөмөр нөөлөг ихтэй, нар гарах шингэх талдаа уул намтай, нар өглөө эрт тусаж, орой хүүшилдэг, хүйтэн жавар хоргодож, хөр цас тогтож хунгарладаггүй, цас орсон ч амархан бараантаж нүүр гардаг хавар эрт цас нь цоохортож хайлдаг, уул нуруу, ухаа толгодын эзвэр энгэр, бэл хормой нөмөр хорго сайтай, хуурай зузаан бууц, дулаан хашаа саравчтай, дөрвөн зүг найман зовхисдоо өвс бэлчээр тэгш нутгийг сонгож өвөлждөг.
- Өвлийн улиралд давжаа жижиг биетэй төлөг, борлон, хөгшин ба



туранхай муу хонь, ямааг сүргээс ялган, отрын нөмөр бэлчээрт маллаж, өглөө, оройд нэмэгдэл тэжээл өгнө.

- Өвлийн бэлчээр хялгана, хазаар өвс, ерхөг, хиаг, ботуул зэрэг цагаалж зонхилсон, шаваг, агь, таар, тарваганы шийр, төрөл бүрийн шарилж, бут, бударгана, хэрс мэтийн шим тэжээл сайтай олон төрлийн ургамалтай байвал нэн тохиромжтой.
- Өвлийн сар эхэлснээс хойш бэлчээрт тогтоон идэшлүүлж сургах ажлыг 15-20 хоног хийдэг.
- Өвөлжөөнд 11-р сарын сүүлч, 12-р сарын эхээр бууна. Өвөлжөө нь бэлчээрийн өвс тэжээл хангалтай, худаг усандаа ойр, алсын салхины нөөлөггүй, нөмөр дулаан, өглөө, орой хүүшилдэггүй байвал зохино. Хонийг бодвол ямаа хотондоо тарж хэвтэн, бууцаа няцалж арвижуулахдаа тун муу учир хүйтэнд ямааны хот амархан автаж хэвтэр дутагдсанаас хээл хаях явдал тохиолдоно. Хэвтэр нь тохирч, дулаан байвал хэвтсэн ямаа босож үймж холхидоггүй.
- Өвлийн улиралд бог малыг бэлчээрт гаргахдаа хотноос зөөлөн цувуулж гаргах, хотлуулахдаа бөөрөөр зөөлөн тууж, шахцалдуулахгүй байхыг анхаарах. Ширүүн хөөж туун үргээж цочоох, хээл нь хүндэрсэн үед халтиргаа бартаатай газар бэлчээрлүүлэх нь хээл хаях нэг шалтгаан болдгийг анхаарвал зохино.





ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН ХАРЬЯАТ МОНГОЛ УЛСЫН ТОД МАНЛАЙ УЯАЧ, УЛСЫН САЙН МАЛЧИН Б.ОТГОННАСАНГИЙН АДУУ МАЛЛАХ АРГА ТУРШЛАГААС...

Адуун сүргийн онцлог нь богино хөлийн мал хүрч чаддаггүй, усгүй буюу цас ихтэйн улмаас ашиглаж чаддаггүй алсын бэлчээрийг намар, өвлийн отроор ашиглах чадвар сайтай, хашаа байр, нэмэгдэл тэжээл бараг шаарддаггүйгээрээ бусад төрлийн малаас ялгагддаг. Түүнчлэн өвлийн тэсгэм хүйтэнд хэвийн идээшилж чаддаг эрс тэс хатуу ширүүн уур амьсгалд гойд сайн зохицсон тэсвэр хатуужилтай мал юм. Мөн маллагааны дэг журамд амархан дасдаг тул бэлчээрт тогтвортой байх эсэх нь эзэн хүний арга ажиллагаанаас шууд хамаарна.

Адууны нэг онцлог нь үдшээр, шөнө дунд, үүрээр гэсэн гурван зогсоол, гурван унтлагатай. Тиймээс 2-3 шөнө дараалан манаж, бууцан дээрээ хөрвөөж амран, биеийнхээ чилээг гаргаж, тухтай хэвтэх буюу зогсоогоороо унтаж амрахад сургах хэрэгтэй. Ингэж чадвал хээл хаяж, тарга хүч шуугдахгүй. Адуучид унаагаа солих гээд адуун дундуур хамаагүй морь хөөж давхих онц биш. Учир нь хээлтэй гүүг гэнэт олон удаа үргээж цочоосноос хээл зулбадаг. Хэрэв гүү хээл хаямаар шинж ажиглагдвал тарваганы халуун бүлээн тос хоолны том халбагаар 2-3 удаа өгөхөд тогтдог. Адууг цан хүүрэг их тураадаг учир үдшийн бүрий, үүрийн жавраар нөмөр, дулаан зогсоолд байлгах хэрэгтэй. Бэлчээртээ хий холхин гэдэс алдах, хомоол нь харлаж эхэлбэл адууны бэлчээр тохироогүйн шинж. Мөн цасны нимгэн зузаан, салхи жаврын цохилтоос хамаарч бэлчээр тохирдоггүй тал бий. Адууг хаврын сүүлчээр отроор маллах нь зүйтэй. Адууг 10 дугаар сарын сүүлчээс буюу өвлийн тэргүүн сарын шинэдээр алсын оторт явуулж, хаврын дунд сард нутагтаа эргэж ирэх нь тохиромжтой. Адууг өвлийн улиралд алсын оторт гаргаж, маллахын гол зорилго, ач холбогдол нь зун, намрын улиралд авсан тарга хүчийг тогтоож, эцээж тураалгүй онд мэнд оруулах, гүүний хээл хамгаалах, гарсан унага бүрийг бүрэн бойжуулах явдал юм.

ХУРДАН МОРЬ УЯХ:

Малынхаа хажуугаар хурдан морь уяж сойх нь малчин хүнээс маш их цаг зав, хөдөлмөр шаарддаг. Тиймээс малчид өвөл, хавар хурдан морио өнжөөгөөд мал төллөөд дууссан зуны дэлгэр цагт уявал бүрэн зав, хүчээ дайчлаад амжилт гаргах магадлал өндөр байдаг.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ СУМЫН МАЛЧИН,
БНМАУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ХОНЬЧИН
Б.ДАШЗЭВЭГИЙН БОГ МАЛ МАЛЛАХ АРГА
ТУРШЛАГААС...**

Бог малыг эцэг өвгөд “гарын мал” гэдэг. Энэ нь эзэн хүний гараар амьдардаг гэсэн үг. Монголчууд эрт дээр үеэсээ л үр хүүхдээ мал маллаж сургахдаа эхлээд хонь хариулуулж сургадаг байсан түүхтэй. Хонио сайн хариулаад сурчих юм бол цаашаа мал маллахад дөхөм байдаг. Бог малыг тогтоож хариулах чинь амархан юм шиг хэрнээ бас их нарийн ажил. Учир нь дөрвөн хөл нь биеэ авч явдаг учир хол явбал хөл нь их амархан ядаргаа

ордог. Тиймээс хонинд явж байгаа хүүхдүүдэд “Хонио тогтоож хариулаарай, гүйлгэж явуулж болохгүй шүү...” гэж хэлдэг юм. Тарга сайн авахуулаад явдлыг нь тааруулчихвал өвөлдөө зутардаггүй амьтан. Дээрээс нь жаахан нэмэгдэл тэжээл өгөөд, дулаан хэвтэрт байлгачихвал тэгээд л асуудалгүй. Их амархан өсдөг учир ашиг шим, ач тусаа ч тийм хурдан хугацаанд өгдөг.

Бог малын үржил төлөвлөлтийн ажил гэж маш нарийн ажил байдаг. Гэвч энэ асуудалд ихэнх малчид тааруухан ач холбогдол өгдөг. Тухайлбал ойрхон хотны хүмүүс хээлтүүлэгч малаа солилцоод тавьдаг, зарим айл бүр хотноосоо хуц, ухна тавьчихдаг. Гэтэл нөгөө мал дотор нь эх нь, дүү нь ч байдаг. Бас манай малчид бог малын хээлтүүлэгч буюу хуц, ухнаа хоёр жил ч болоогүй солиод малаа давжааруулаад байна. Тиймээс мэргэжлийн малын эмчээр малаа эмчлүүлж, мэргэжлийн мал зүйчээр малынхаа үржлийг хийлгэж сурах хэрэгтэй. Мөн залуу малчид ахмад үеийн туршлагатай малчдынхаа мал маллах арга ухаанаас суралцах хэрэгтэй.

ЗАЛУУ МАЛЧДАД ЗӨВЛӨМЖ: Мал маллана гэдэг их нарийн ажил. “Малчин хүн бол мянган мэргэжлийн эзэн” гэж гэж үг бий. Үнэхээр ч тал бүрийн авьяас чадлыг мал, байгаль, амьдрал гурав малчин хүнээс шаарддаг. Малчин хүн малаа маш сайн ажиглаж, шинждэг байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хүн бүр өөр, өөр байдаг шиг айл бүрийн мал өөр байдаг юм. Тэр болгоныг мэдэрч чаддаг байх юм бол тэр сайн малчин. Монгол оронд хамгийн хүндээ зохисон мэргэжил бол мал гэж би боддог юм. Байгаль, цаг уурын олон хэцүү үеүд малчин хүнд тохиолддог. Тэр болгонд шантралгүй урин сайхан цаг ирнэ дээ гээд зүтгэх хэрэгтэй.



БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЛИГ СУМЫН ТЭМЭЭЧИН МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР Ч.СУГАР-ОЧИРЫН ТЭМЭЭ МАЛЛАХ АРГА ТУРШЛАГААС...

Тэмээний хувьд өл даадаг, ган, зудад тэсвэртэй, уртын саальтай, Идээ цагаа нь маш өндөр чанартай, ашиг шим нь арвин сүрлэг сайхан амьтан. Гэхдээ тэмээ малчин хүнээс илүү их хөдөлмөр, хүч шаарддаг. Яагаад гэхээр холын бэлчээртэй, эдэлж, сургахад бие, чац томтой учир маллахад

чамгүй хүндрэлтэй. Мөн ингэ жил өнжиж ботголдог тул бусад малаас өсөлт удаан бөгөөд маллагаа дутагдвал төл бүр мал болох магадлал багатай учир хариулага, арчилгаа ихээхэн шаарддаг. Боос ингэ ботголох дөхөөд ирэхээр шилэрч, гарсан ботгоо осгоож төл алдах магадлал өндөр тул өдөрт хариулж, шөнөд уяж хөллөх зэргээр сайн хамгаалах хэрэгтэй. Нялх ботго урт хүзүүтэй ч эхээс төрсний дараа нэг сар болохоос нааш хошуу нь газарт хүрдэггүй онцлогтой бөгөөд хошуу нь газарт хүрмэгц өвсөнд ордог.

Тэмээний нутаг бол говь. Говьд задгай ус ховор учир ихэнх айлууд худгаас малаа усалдаг. бас ганц худаг тойроод 5-6 айл буудаг учраас ус нь амархан шавхагдчихаад мөд ундардаггүй онцлогтой. Тиймээс шөнө 04:00-05:00 цагт босох шаардлагатай байдаг. Тэгэхээр тэмээчин хүн бол маш эртэч байх хэрэгтэй. Сүүлийн үед эрлийз тэмээ их болсон. Монгол тэмээнээс хурд, тамир тэнхээний хувьд эрлийз тэмээ хол илүү байдаг. Говь цөлийн өвс ургамал, ус, эрдэс бодис ихтэй байдгаас тэмээ давс хужрыг ихээр хэрэглэдэг. Тиймээс бусад малаас илүү хужир, ус, ургамал сайтай нутагт хариулж маллах хэрэгтэй. Нэг тарга хүчээ алдаж турсан тэмээ буцаж таргалахдаа удаан байдаг учир хэтэрхий турааж болохгүй.

ЗАЛУУ МАЛЧДАД ЗӨВЛӨМЖ: Малчин хүн ган, зуд, цас, шуургатай олон хахир жилүүдийг туулдаг. Тэглээ гээд бид байгалийн хатуу ширүүний өмнө хүчин мөхөстөхгүй байх ёстой. “Мал дагавал ам тосодно” гэж өвөг дээдсийн сайхан сургаал байдаг. Эзэн хүн өөрөө хичээвэл малын буян үнэхээр их, Монгол хүнийг малгүйгээр төсөөлөхийн аргагүй. Миний хувьд малчин хүн бол залуу гэлтгүй тэнгэр, сар мичид, одны байдлыг гярхай ажиглаад цаг агаар ямар болохыг шинжих чадвартай байх ёстой гэж боддог. Тухайлбал од, сар тохиох үед тэнгэрийн байдал, цаг уурын байдал ямар байгааг нь ажиглаад ирэх сар, улирлынхаа байдлыг шинжчих мэдрэмж, мэдлэгтэй байх хэрэгтэй.



МОНГОЛ УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ЛУВСАНДАШИЙН ДАВААДАШИЙН ҮХЭР МАЛЛАХ АРГА ТУРШЛАГААС...

Үхэр сүрэг маллагаа нь таарвал хамгийн ашиг шимтэй маллахад учиргүй их арчилгаа шаардаад байдаггүй амар мал. Гол нь бэлчээрийг нь тааруулах нь чухал. Жилийн 4 улиралд соргог бэлчээрээс олон янзын ургамлаар идээшилж тарга хүчээ богино хугацаанд нөхөн авдаг учир малчин хамгийн гол нь бэлчээрээ л зөв сонгох хэрэгтэй. Мөн Монгол үхэр зун, намрын улиралд өөх ихээр хуримтлуулдаг нь цаг агаарын хүнд нөхцөлийг даван туулах энергийн эх үүсвэр болдог учраас

зун, намрын улиралд тарга хүч сайн авахуулах нь чухал байдаг. Ер нь мал өөрт нь тохиромжтой нутаг, бэлчээр газар, ус хужиртай газар өөрөөр хэлбэл “өвсний сайныг идэж, усны цэнгэгийг ууж” байж үрждэг, шимээ өгдөг амьтан.

Үхрийг хүйтний улиралд уул нуруудын өвөр нам дор, хотгор хонхор бэл, хялганат, хиагт, дэрст, энгэр бэлийн биелэг, улалж, сибир хялгана, агт бутнуур ерхөгтэй бэлчээрт бэлчээх хэрэгтэй. Харин дулааны улиралд сахлагдуу ургамалтай зөөлөн хөрстэй жалга, судаг, уужим тал, бэл хоолой, зоо нуруу ухаа толгойд бүхий өндөрлөг сэрүүн нутагт маллах нь тохиромжтой. Харин сарлаг үхрийн хувьд өндөр уулын бүсэд амьдрах илүү тохиромжтой байдаг учир малчин хүнээс их хөдөлмөр зүтгэл шаарддаг. Тэгэхээр сарлагтай айлууд аль болох өндөр уул, хадтай газраар нутаглах нь зөв.

Зөв нүүдэл хийх нь малчдад маш чухал. Ногоо сайхан байна гээд нүүгээд байхаар ус хужир дутагддаг тал байдаг. Ус хужир нь болоод ирэхээр ногоо нь дутагддаг юм. Тэгэхээр үүнийг мэдрэмжээрээ л тохируулна. Мал их нүүснээрээ таргалдаг юм биш. Мөн нэг нутагт удаан сууснаараа ч турдаг юм биш. Малчин хүн өөрийнхөө малыг яаж байгааг нь байнга ажиглаж байж л малынхаа тарга, тэвээргийг тохируулж чадна.

ЗАЛУУ МАЛЧДАД ЗӨВЛӨМЖ: Ажилчин хүн зөвхөн ажил, ар гэртээ санаа зовдог бол малчин хүн мал нэг бүрийнхээ төлөө санаа зовж, амрах, унтах эрх байдаггүй улс. Тиймээс малчин хүн хамгийн гол нь эртэч, гярхай, хөдөлмөрч байх хэрэгтэй. Малыг хөдөлмөрч хүн л малладаг юм шүү дээ. Хөдөлмөрч хүний л мал нь өсөж, ахуй амьдрал нь арвижин дээшилдэг. Урин дулаан улиралд хадлан тэжээлээ хангалттай нөөцөлж, хашаа хороо, өтөг бууцаа засаж өвөлдөө сайтар бэлдэж, зун, намрын цагт малаа тарга тэвээрэг авахуулж, отор нүүдлийг цаг тухайд нь оновчтой хийх шаардлагатай.

VI БҮЛЭГ

ЭРҮҮЛ МЭНД
ЭРХЭМ БАЯН



ЭРҮҮЛ МЭНДЭЭ АНХААРААРЫ...

Эрүүл мэнд бол юугаар ч үнэлшгүй, алдаж болохгүй хамгийн эрхэм зүйл. Тэр дундаа малчин түмэнд маань эдийн засгийн хэрэгцээнээс илүү хамгийн чухал зүйл бол эрүүл мэнд юм. Хүмүүс сайхан амьдралын төлөө, мөнгө олохын тулд эрүүл мэндээ золиосолж болохгүй билээ. Өвчин баян, хоосныг ялгаж ирэхгүй учир өвдчихвөл хэчнээн их өв хөрөнгө, мөнгө байгаад амь насыг чинь аварч чадахгүй шүү дээ. Бие тань өвдөөгүй байсан ч жилд заавал бүрэн үзлэг, шинжилгээнд хамрагдаж байх хэрэгтэй. Эрт оношлуулж байж эрт эмчлэгдэнэ. Хүн эрүүл байж л ажил хийнэ, малаа маллана. Тиймээс бид эрүүл мэндийн бяцхан зөвлөгөөг бэлтгэсэнээ хүргэе.

■ ЭРҮҮЛ МЭНД:

- Хүн бүр өөрсдийн болон гэр бүлийнхнийхээ эрүүл мэндэд онцгой анхаарах;
- Цаг агаарын бэрхшээл, отор нүүдлийн үед дулаан хувцаслаж осгох, хөлдөхөөс сэргийлэх;
- Ахмад настан, жирэмсэн, нярай хүүхэдтэй эхийг аль болохоор гэр болон төв суурин газарт байлгах, отор нүүдлээр явуулахгүй байх;
- Эмнэлгийн яаралтай тусламж авах шаардлагатай тохиолдолд хамгийн ойрхон байгаа эмч эмнэлэгт хүрч болох зам, харилцах утасны лавлах, мэдээлэлтэй байх;
- Тэжээллэг хоол идэх, хүүхдийг хөхөөр дагнан хооллох, бага насны хүүхэд болон жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд тэжээлийн бэлдмэлийг тогтмол хэрэглүүлэх;
- Хувийн ариун цэврийг сайтар сахих;
- Үхсэн малын сэг, зэмтэй болгоомжтой харьцан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж халдваргүйжилт хийх;

■ МАЛЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРСДЭЛ

Манай малчид бол таван эрдэнэ мал сүргийнхээ эзэд гэдгээрээ дэлхийд хаа ч байхгүй өвөрмөц өрхийн үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид юм. Иймээс ч Монголын төр малчин хүнийг “мянган мэргэжлийн эзэд” хэмээн зарлан тунхагласан бөгөөд ийм чухал мэргэжлийн хүмүүсийн хувьд мал аж ахуйн аливаа ажлыг аюул, осолгүй гүйцэтгэж амь нас, эрүүл мэндээ хамгаалах нь хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангаж байна гэсэн үг. Хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг нь хамгийн товчоор хэлбэл ажил хөдөлмөр эрхэлж буй хүн болгон хором бүр өөрийнхөө аюулгүй байдлыг хангаж ямар нэгэн аюул, эрсдэлээс өөрийгөө хамгаалж чаддаг байна гэсэн үг юм. Ажилчин хүн ажлын өдрийн 8 цагийн туршид ямар нэгэн даргын удирдлага, байнгын хараа хяналтын дор ажлаа гүйцэтгэдэг бол малчин хүн 24 цагийн турш өөрөө өөрийгөө хянаж



аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлага гардаг онцлогтой. Яагаад гэвэл цаг агаарын гэнэтийн аюул 24 цагийн туршид хэзээ ч, хаа ч тохиолдох эрсдэлийг дагуулж байдаг. Малчны хөдөлмөр нь цаг хугацаанаас хамаарал багатай, өргөн мэдлэг, арвин туршлага шаарддаг, нар, сар, од эрхэс, өвс ургамлын гарц байдал, малын элдэв хөдөлгөөнөөр цаг агаарын шинж байдлыг соргог ажиглан ажил төрлөө зохицуулж, цаг нартай уралдан ажлаа амжуулдаг онцлогтой учраас хөдөлмөрийн аюулгүй байдал буюу аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхгүй ажиллах нь нэн тэргүүнд анхаарах асуудал юм. Монголын жирийн малчин иргэд мал аж ахуйн үйлдвэрлэлийн олон талт ажлыг аюул, осолгүй гүйцэтгэх “алтан дүрэм”-ээ хэдэн зууны туршид өөрсдийн ажил, амьдралын баялаг туршлага, ахмад малчдын арга барил дээр тулгуурлан өөрсдөө зохиож өвлүүлэн тээж яваа гайхамшигтай ард түмэн.

Малчдын хийж буй ажил нь “гурван багц эрсдэл”-ийг дагуулж байдгаараа бусад салбарын ажил мэргэжлийн хүмүүсээс ихээхэн онцлогтой, ялгаатай гэж хэлж болно.

Нэгдүгээрт: Мал сүрэгтэй харьцах үед тохиолдох эрсдэлүүд:

Малыг барих, туших, чөдөрлөх, ногтлох, буйллах, дөрлөх, уналга эдэлгээнд сургах, ашиглах, ашиг шимийг нь авах, зоо-мал эмнэлгийн арга хэмжээнд хамруулах, имнэх, тамгалах, хашаа хороонд шахах, тэжээх, услах зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүхий л үе шатны ажил нь үргэлжид эрсдэл дагуулж байдаг тул малтай байнга болгоомжтой харьцаж аюулгүй байдлаа хангаж ажиллах нь чухал.

Хоёрдугаарт: Байгаль, цаг агаарын сөрөг нөлөөллийн эрсдэлүүд:

Бэлчээрийн мал аж ахуй зонхилсон манай орны хувьд малчдад аюул үүсгэдэг хамгийн ноцтой эрсдэлийн нэг бол байгаль, цаг агаарын эрс тэс өөрчлөлт, сөрөг нөлөөллүүд байдаг. Малчдын хувьд хүчтэй салхи, цасан шуурга, хүйтэн бороо, хөр цас, мөндөр, үер ус, аянга, цахилгаан зэрэг цаг агаарын аюултай үзэгдлүүдтэй байнга тулгардаг бөгөөд өргөн уудам газар нутагтай манай оронд дээрх аюултай үзэгдлүүдийг “нүдэн баримжаа, гярхай ажиглалт”-аар урьдчилан танин мэдэж ажил, амьдралаа зохицуулж эрсдэлээс хамгаалах нь өнөө үед ч ач холбогдолтой хэвээр байгаа юм. Монгол ардын зүйр цэцэн үгэнд “Баатар хүн нэг суманд, Баян хүн нэг зудад” гэдэг мэргэн үг байдгийг санаж бэлтгэлээ базааж байхад илүүдэхгүй болов уу.

Гуравдугаарт: Машин, техниктэй харьцах үед тохиолдох эрсдэлүүд:

Монголын хөдөөд сүүлийн жилүүдэд автомашин, мотоциклыг малчид ажил амьдралдаа өргөн хэрэглэж нүүдэл, суудал хийх, мал эрж хайх, адгуулж маллах, тууварлах ажлаа техникээр гүйцэтгэх болсноор осолд орох явдал нэмэгдэн малчдад нэг бүлэг аюул бий болж олон хүн амь насаа алдаж, эрүүл мэндээрээ



хохирсоор байна. Үүний гол шалтгаан нь малчид машин, мотоцикл жолоодох ур чадвар, дадлага туршлага дутагдсантай холбоотой. Иймээс машин, мотоцикл жолоодох хүн заавал дамжаа, курст сууж “номыг нь үзэж, ногоотой шөлийг нь уух” хэрэгтэйг анхаарч байх нь чухал. Малчдын хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг нь маш өргөн хүрээтэй, олон хүчин зүйлээс хамааралтай, том асуудлууд учраас цаашид үүнийг дэлгэрүүлж нарийвчлан авч үзэх нь чухал юм.

АНХНЫ ТУСЛАМЖ ГЭЖ ЮУ ВЭ?

Анхны тусламжийн гол зорилго бол хүний амь насыг аврах арга хэмжээ бөгөөд ямарваа нэгэн өвчин эмгэг болон осол гэмтлээс үүдсэн амь насанд аюултай хүндрэлээс сэргийлэх ба эдгэрэлтийг хурдасгах цогц үйл ажиллагаа юм. Аливаа осол гэмтэлд өртсөн хүний биеийн байдлыг цаашид улам хүндрүүлэхгүй байх, нэмж гэмтэл авахаас хамгаалах, биеийн чухал эрхтний үйл ажиллагааг сэргээх, хэвийн байдалд оруулахын тулд тухайн газар дээр нь үзүүлэх арга хэмжээг анхны тусламж гэнэ.

АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ:


1. Анхны тусламж үзүүлэх гэж буй хүнийхээ биеийн ерөнхий байдлыг ажиглаж хэрхэн тусалж чадахаа шийдвэрлэнэ. Сандарч болохгүй тусалж чадна гэдэгтээ итгэлтэй байж тайван ажиллана.
2. Амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөхцөл байдал, ноцтой шинж тэмдэгүүдээс эхлэн тусламж үзүүлэхийг эрмэлзэнэ. Амьсгал, судасны цохилт, арьсны өнгө, биеийн дулаан цус алдсан эсэхийг шалгана.

АНХНЫ ТУСЛАМЖ ХЭРХЭН ҮЗҮҮЛЭХ ВЭ!!!

Анхны тусламж	
ЯС ХУГАРАЛТ	
	<ul style="list-style-type: none">• Ил юм уу, битүү хугаралтын аль алинд нь (цус тогтоож, ариутгасан боодол тавьсны дараа) эмч иртэл гэмтсэн мөчийг хөдөлгөөнгүй байлгана. Энэ нь өвдөлтийг багасгаж, хугарсан ясны цаашдын шилжилтийг зогсоодог.
	<ul style="list-style-type: none">• Хөдөлгөөнгүй байлгахын тулд бэлэн чиг баригч болон саваа, банз, шугам, фанерийн өөдөс гэх мэтийг ашиглана. Битүү хугаралтын үед нэрвэгдэгчийн хувцсыг тайлах хэрэггүй.
	<ul style="list-style-type: none">• Харин чиг баригчийг шууд хувцас дээр тавих хэрэгтэй. Өвдөлтийг багасгахын тулд бэртсэн газар хүйтэн жин тавих шаардлагатай.



Анхны тусламж



ЦУС АЛДАЛТ

- Нүүрний доод хэсгээс цус алдвал эрүүний судсыг эрүүний доод зах руу дарна.
- Дух, шанаанаас цус алдвал шанааны судсыг чихний дээд захын урд дарна.
- Толгой, хүзүүнээс цус алдвал гүрээний судсыг аман хүзүүний орчинд дарна.
- Эгэм, мөрнөөс (мөрний орчмын мөчүүдээс) цус алдвал эгэмийн хонхорын судсыг яс руу нь дарна.

Анхны тусламж



ЦУС АЛДАЛТ

- Бугалгаас цус алдвал мөрний дунд дотор талаас нь судсыг мөр рүү дарна.
- Гарын шүү, хуруунаас цус алдвал шүүн дээр хоёр судсыг (салаа ба тохойны) дарна.
- Шилбэнээс цус алдвал өвдөг дээрх судсыг дарна.
- Гуянаас цус алдвал гуяны судсыг аарцагны яс руу шахаж дарна.



Анхны тусламж



ХӨЛДӨЛТ

- Чийгтэй, хүйтэн орчноос нь холдуулж хуурай, дулаан газар аваачих;
- Хөлдөж осгосон хүнийг аль болох өөрөөр нь явуулахгүй, хөдөлгөхгүй байхаар зөөвөрлөх;
- Хүйтэн, нойтон хувцсыг тайлах;
- Аажим аажмаар дулаацуулах;
- Хөлдсөн хэсгийг спирт, үнэртэй ус зэргээр арчиж аажмаар гэсгээх;
- Хөлдсөн гар, хөлийг мөстэй, хүйтэн усанд дүрэх, эсвэл цасаар үрж зөөлөн иллэг хийж, цусны эргэлтийг аажмаар сэргээх;
- Халуун цай уулгах;
- Хөлдсөн хэсэгт хөвөнтэй зузаан боолт хийх;
- Гүн хөлдөлтийн үед анхны тусламжийн арга хэмжээг авч мэргэжлийн эмчид хүргэх нь чухал.

Анхны тусламж

ТҮЛЭГДЭЛТ

- Түлэгдсэн хэсгийг хүйтэн ус гоожуулан угааж хөргөнө
- Өвчин намдаах эм уулгана
- Тусламж үзүүлэгч гараа сайн угаана
- Наалдсан эдийг салгах оролдлого бүү хий
- Элдэв тос, гүрил, гель, техникийн тос бүү түрх
- Үүссэн цэврүүг бүү оролд
- Түлэгдлийн талбай том бол эмнэлэгт хүргэ
- 2-3-р зэргийн түлэгдэлтэй бол эмнэлэгт хүргэ



VII БҮЛЭГ

ЭРҮҮЛ МАЛ МОНГОЛЫН
БАЯЛАГ



МАЛ СҮРГИЙГ ЗАРИМ ӨВЧИН ЭМГЭГЭЭС ХАМГААЛАХ АРГА

■ ХУЖИРТ ХОРДОХ БУЮУ ЦУРЬДАХ:

Хужирссан малыг гэнэт хужир мараанд оруулах буюу хужирт оруулсны дараа шууд услах зэрэг нь цурьдах (хорддог) шалтгаан болдог. Амнаас нь хөөс цахрах, хар цяцга алдах, гэдэс дүүрч тийчлэх, хэвтэх шинж тэмдгээр илэрнэ. Тиймээс малыг заавал ханатал усалсны дараа бог малыг сайн идүүлсний дараа хужирлана. Хужирт түлэгдсэн малыг нойтон хар шаварт биеийн талыг далд ортол булж, усаар цохиулна. Үнээний түүхий сүү, гурилан зутангийн аль нэгийг бог малд 2л, бодод 4л уулгана. Мөн модны нүүрс, үнсийг усаар зуурч уулгаж болно.



■ ХӨЛДӨЛТ:

Цас зудтай их хүйтэн өвөл малын хөх дэлэн, чих, сүүл туурай хайрагдаж хөлдөнө. Мөн хүйтэнд гарсан төлийн хөл мөч хөлдөх явдал олон тохиолдоно. Хөлдсөн эрхтнийг тэр даруйд нь хүйтэн усанд дүрэх, цасаар үрэх зэргээр аажмаар гэсгээнэ. Тогооны хөөг тосонд зуурч, хөлдсөн газарт түрхвэл сайн.

■ ТУЙЛДАА:

Мал туйлдвал загасны тос уулгах, мөн махны шөл цутгаж өгөхөд тэнхрэх нь хурдан байдаг. Цагаан агийг хатааж хандлан өгнө. Үхэр, адуунд хонины сүүг өдөрт нэг аягыг өгөх, тураалтай борлон, төлөг, бяруунд адууны элгийг шүдэнзний хайрцагны хэмжээтэй хэрчиж, давс хужир түрхэж идүүлэх, зоодойг 1 литр халуун усанд хийж хандлан хөргөөд 50-100 мл-ээр өдөрт хоёр удаа өгөх зэрэг монгол уламжлалт аргууд байдаг. Мөн шар будааг төрөл бүрийн малын махны шөлөнд сайн шазлаад бог малд 300мл, бодод 500 мл хэмжээгээр уулгаж болно. Адуунд шар тосыг шулуун гэдсэнд бургуйдах, хургыг тарваганы тосоор тэнхрүүлэх гээд олон мэдээлэл туршлагыг малчид андахгүй мэддэг.



МАЛ ХАТИНГАРАХ:

Хатанги малд үнээ, хонины сүүг саамагц халуун бүлээнээр нь адуунд хагас шанага, тэмээнд 1-2 шанагыг өгч нэмнээд хөлөргөн уяж, сойно. Бог малын хамрын сиймхийг хатгах, хааны судсыг ханаж цус авах зэргээр аргалдаг.

МАЛЫН ГҮЗЭЭ ХИЙГЭЭР ДҮҮРЭХ:

Хонь, ямаа, үхэр, тэмээний гүзээ хавар гэнэт нялх ногоонд оруулахад, чийг шүүдэртэй үед бэлчээхэд, хөгцөрч ялзарсан өвс тэжээл идүүлэхэд, зарим хорт ургамал идүүлэх зэрэг янз бүрийн шалтгаанаар гүзээнд их хэмжээний хий үүсч, хуримтлагдан гүзээг дүүргэн цэндэгдэж хийгээр дүүрч тийрнэ. Малын зөв талын хэвлийн дээд талд бөөрний хонхолзуур хэсэгт дарах, нухах, үрэх зэргээр хийг гаргана. Махны тостой шөл уулгаж, будааны хатуу архийг шингэлж өгнө, дараа нь хөлөртөл хөөж, тууна. Мөн хатгана.





■ МАЛЫН ШЭЭС ХААГДАХ:

Голдуу эр малынх илүү хаагдана. Шээс нь хаагдсан хонь байн, байн хэвтэж, босон хий майлан дүлж зовиурлана. Хүндэрсэн үед бөгсөөрөө савж унан босч чадахаа больж, яраглан хэвтэнэ. Халуурна. Ямааны шээс хаагдахад сүүлээ сөхөж, дүлэх, майлах, орилох бөгсөөрөө унах шинж илэрнэ. Шээс хаагдсан малд саванг усанд уусган цийдэм маягтай болгоод бод малд дунд шаазангаар 2 удаа уулгавал сайн. Мөн цахилдагны үндэс, тарваган шийр, алирс, ямаан арцны аль байгааг усанд буцалгаж уулгана.



■ ШИВЭЭТЭХ (БӨӨДИЙТӨХ):

Шивээт хялгана их гарсан жил хонь, тэмээ шивээтэх нь их. Боловсорч гүйцсэн шивээ хонь, хурганы хүзүү, хонго, хэвлий гэдсэнд асаж, улмаар арьс маханд шивж гэмтээгээд, цаашаа мах булчингийн хөдөлгөөнөөр улам бүр гүн рүү шигдэж яргана. Хоолой багалзуур руу шивж гэмтээх бөгөөд улмаар цоорч идээ бээр гоожин, турж эцэн, хөлийн салаа, шивэрт шивсэн бол доголно. Энэ үед юуны түрүүн шивээтэй бэлчээрээс нүүж, холдоно. Бэлчээр сэлгэхийн хамт шивээтсэн мал бүрийн барьж үс ноос арьс, маханд шигдсэн шивээг түүж авна. Багалзуурын шивээг авч шархыг эмчилнэ. Шивээтэй бэлчээрт хялгана шивээлж байх үед олон үхэр, адуу бэлчээх, адуу туучуулах аргыг хэрэглэж сэргийлдэг.



МАЛЫН ТӨЛИЙН ӨВЧИН

■ ТӨЛЛӨХ МАЛ БЭРХТЭХ:

Мал зохих хугацаандаа төллөж чадахгүй сунжрах, хүндрэх, төл нь гарахгүй болохыг бэрхтэх гэнэ. Хээлийн ус цухуйснаас хойш 30-40 минутанд төл нь гарвал хэвийн, үүнээс удвал төллөлт удааширлаа гэнэ. Хээлтэй малыг хад чулуу ихтэй, бартаатай хэвгий газарт хариулах, унаж өөдүүлэх хээлдэж ядрах үед хээлийн байдал өөрчлөгдөн гэмтэж бэрхтдэг. Бэрхтсэн бог малын хойд хоёр хөлнөөс нэг хүн, урд хөлнөөс нэг нөгөө хүн тус тус барьж өөхийгөөр дээш харуулан хэд хэдэн удаа хөлбөрүүлэн хээлийн байрлалыг засна. Бог мал бэрхтвээс ууц, цавь орчимд хүйтэн жин тавина. Бэрхтэлт хүндэрсэн бол гараа савандан малын баян савруу оруулж, суйлан төлийн байрлалыг засаж зөв байрлалд оруулна. Мөн малыг дүлэх үеийг тааруулан төлийг зөөлөн татаж гаргана. Хээл гарсны дараа эх мал халуурвал цагаан мөөгний шөл, хөх дэгдний ханд уулгана.



■ ЗУНГАГ СААТАХ:

Эхийнхээ гал уургийг дутуу хөхсөн огт хөхөөгүй бага зэрэг шалтгаанаас болон нялх унага, хурга, тугалын хар зунгаг түгжрэн саатах явдал байдаг. Зунгаг саатсан төл хэвтэмхий болж, бэгцийж зогсохоос гадна бие нь суларч сүүлээ хөдөлгөн хий дүлэх шинжтэйгээр хэвтэж, босно. Энэ үед олон уулзах ясан дээр халаасан элсээр жин тавихад үр дүнтэй. Мөн үнээний нэг шанага



хярамласан сүүнд шүдэнзний хайрцагны хиртэй барааны саванг жижиглэн зорж хийгээд дээр нь хоолны халбага шар тос нэмэн биеийн халуунтай адил болтол халаагаад унаганы бөгсийг өргөж шулуун гэдсийг бургуйдна. Эхийн сүүгээр бургуйдаж болно. Түгжирсэн зунгагийг хуруугаараа гаргаж авна.

■ ТӨЛИЙН АМЬСГАЛ БҮТЭХ:

Төллөж байгаа мал бэрхтэх, төл эхийн хэвлийд буруу байрлах, хээлийн ус эрт гарах, төрж чадахгүй тамирдаж, сунжрах зэрэг шалтгаанаар төл гарах үедээ бүтдэг. Энэ үед татаж гаргасан төлийн хамар амны салс салиаг түргэн арилгаж хошуу, хамрыг гараараа шувтран шингэнийг шавхарна. Үүний хамт ам, хамар, чих рүү нь хүчтэй үлээж цочроон амьсгалыг авахуулна. Мөн төлийн цээжийг тэнийлгэх, хавчийлгах үйлдлийг ээлжлэн хийж амьсгалуулна. Толгой руу нь ус цацна.



■ ШАР УУРАГ ЗАНГИРАХ:

Нялх хурга, ишиг, тугалын ходоодонд хөхсөн уураг, сүү бөөгнөрөн хатуурахыг уураг зангирах гэнэ. Нялх төл даарч, бээрэх, эхээ хэт их хөхсөнөөс уураг зангирна. Зангирсан уураг нь боловсорч шингэдэггүй учир өвчин болно. Ходоодыг хэвлийн гаднаас барьж үзэхэд бөөрөнхийдүү хатуу зүйл байгаа нь мэдэгдэнэ. Ийм төл эхээ хөхөхгүй болж, өнхөрч ойчин гэдсээ ажиглаж харна. Мөн цовхрох, бэгцийж зогсох зарим үед чацга алдах, зовиурлах, яраглах, хэвтэх, босох, хар шүлс гоожуулах, хошуу хөрөх шинжээр бие суларч байгааг ажиглаж болно. Энэ үед хэвлийд халуун жин тавих буюу төлийг гэдэс талаар



галд ээнэ. Мөн төлийн ходоодонд байгаа зангирсан уургийг гаднаас нь барьж зөөлөн имрэх, чимхэх замаар няцалж жижиг болгоно. Энэ заслыг маш болгоомжтой хийх бөгөөд өвтгөж болохгүй. Халаасан шар тос нэг балга хиртэй уулгана. Сүүнд иодын ханд 5-8 дусал нэмж уулгана.

■ ХУРГА ИШИГНИЙ ЭРЭЭН УУШГИ ӨВЧИН:

Хурга, ишиг бусад малын төлийг цочир дааруулах, жавар салхинд цохиулах, дулаан байрнаас хүйтэнд гаргах зэргээр халуун хүйтний эрс солигдолд оруулах, тоос шар бууц ихтэй хот, хашаа хороонд байлгах чийгтэй хүйтэн өтөг, шинхэг ихтэй пүнз байранд удаан байлгахад уушги өвчлөн бие сулран зарим үед халуурна. Нус нуух гоожин зовиуртай амьсгалж эхээ хөхөхөө больж ханиалгана. Энэ үед адууны халтар хомоолын үнсийг бүлээн усаар зуурч суганд нь халуун жин тавина. Нохойн хошуу, нарс хусны шилмүүс, морин шоргоолжны ханд уулгана. Мөн цэнхэр дэгд хандалж өгнө.



■ ТӨЛ ДАВХАР ХҮЙСТЭХ:

Нялх төлийн хүй үрэвсэх нь байх бөгөөд малчид үүнийг давхар хүйстэй гарлаа гэнэ. Давхар хүйстэй төл гэдэг нь хүй, элгийг холбосон цусны судас үрэвсэж байгаа хэрэг юм. Хүйний гадна унжсан үзүүр бохир зүйлд шүргэж уул судсанд халдвар орохыг хэлнэ. Энэ өвчин нэг гарсан хот айлдаа дахин, дахин гарна. Байран маллагааны үед их тохиолддог. Хүйний үрэвсэл буюу давхар хүйдэхэд нялх төлийн хүй нь орчноосоо бохирдон идээлж баална. Төл хөхөхдөө дургуй болж бээцийж зогсоно. Хэвлий хүйний орчимд эмзэг хөндүүр




болно. Өвчин хүндэрвэл хүй хавагнаж чацга алдаж, халуурна. Энэ үед төлийн хүйсний орчны үсийг хайчлан хар цайгаар угааж архи шингээсэн хөвөнгөөр даруулж бооно. Хүйний идээлсэн хэсгийг огтолж хаяна. Хүй айсхай мөгөөрсний хооронд хэвлийн цагаан шугамнаас аль нэг хажуу тийш 1-2 см зайд цоройг 2-4 см урт цоолоод цэвэр махир зэс утсан дэгээгээр хүйний ёзоорын холбогч судсыг гогодон гаргаж ирээд дан шөрмөсөөр боож, боолтны хоорондуур тайрна. Цоройг шөрмөсөөр оёдог. Энэ ажилбарыг цэвэрхэн хийхэд хүйний үрэвсэл бүрэн эдгэрдэг. Хутга шөрмөс зүүг хэрэглэхийн өмнө усанд чанана. Мөн антибиотик тарих зөвлөмж бий.

■ **НЯЛХ ТӨЛ ЧАЦГА АЛДАХ (НЯЛХ ТӨЛИЙН БИЖ):**

Нялх төлийг сүүнд нь хэт цатгах дааруулах, муудсан хүйтэн дан сүүгээр угжих, дэлэн нь айсан эхийн сүү хөхүүлэх үед чацга алдана. Чацга шар цайвар, сүүлдээ ногоон залхагтай заримдаа цустай, исгэлэндүү үнэртэй болно. Чацга алдсан төл хүндэрвэл эхээ хөхөхөө больж, эвгүй үмхий үнэртэй чацга тасралтгүй алдах ба төлийн шингэн их алдсанаас болж нүд нь ширгэж бие нь суларч, хошуу, чих мөч нь хөрч шилээ татан унана. Энэ үед төлийг эхэд хөхүүлэхгүй сойж, 1-2 удаагийн хөхөх хугацаанд сулавтар давстай хар цай, хярамаар угжиж, хад, гоёо, сөд, алтан гагнуур, төлөгч өвс, үрэх мэхээр, ганга, лидэр зэрэг эмийн ургамлын хандны аль нэгийг уулгана. Мөн хросол, рингерийн уусмал зэрэг олон найрлагатай давсны уусмалыг ойр ойрхон өгөх нь хордлогоос сэргийлж өвчнийг хурдан эдгээнэ.



МАЛЫН ӨВЧИН ЭМГЭГИЙГ ЭМЧЛЭХ АРДЫН АРГА



■ ЦАХЛАЙ ӨВЧИН:

Малчид цахлай өвчнийг аргалахдаа цус гартал нь хусаад халуун тос түрхэх эсхүл тос түрхээд халааж жигнэх зэрэг арга хэрэглэдэг. Тухайлбал адуу болон тарваганы тосыг тогооны хөөтэй хольж халаагаад түрхэхэд цахлай эмчилгээ авч эдгэрнэ. Мөн бургасны тортог /хальс/ буюу хар модны гөлгөн боргоцой зэргийг халуун тогоонд жигнэхэд ялгардаг шүүсэрхүү зүйлийг авч цахлайд халуунаар нь түрхдэг. Ингэж түрхэхийнхээ өмнө цахлайг цус гартал сайн хусаж цэвэрлэх хэрэгтэй.

■ ШИРХ ӨВЧИН:

Ширхийг эмчлэн устгахад хамгийн сайн зүйл бол арц, мойл, аргалын үнс, улаан тамхи, хар шаваг, цагаан ортууз, зээргэнэ зэрэг өвс ургамлын зүйл юм. Малчид эдгээрийг нунтаглаж цацахаас гадна уусмал ханд маягаар бэлтгээд ширхэтсэн малыг шавшина. Мөн ширхнээс хамгаалахын тулд дээрх өвснүүдийн нунтаг ба ханд уусмалыг малын байр хэвтэрт цацдаг. Үхрийн хөх аргалын үнсийг ширхтэй малд түрхэхэд их сайн гэж хууччуул ярьдаг.

■ ХАМУУ ӨВЧИН:

Төрөл бүрийн малын үс, арьсыг гэмтээж эдийн засгийн асар их хохирол учруулдаг өвчний нэг бол яах аргагүй малын хамуу өвчин юм. Хамуу нь хуурай, нойтон /маагуу/ арьс идэгч гэж ялгагдах бөгөөд тус бүрдээ онцлог шинж тэмдэг бүхий өвчин юм. Гэвч хамууны гол шинж тэмдэг нь толгойн хэсэг тухайлбал нүдний эргэн тойрон зовхи, чихний угаас эхлэн чамархай, самсаа, хоншоор, дээд, доод уруул, суга, цавь, хондлой хавийн үс халцарч арьс зузааран улмаар



шархалж идээ, цус гоожих зэргээр илэрнэ.

Малчид маагуу гэж нэрлэдэг өвчин бол хамууны нэг төрөл бөгөөд хондлой, ууц, орчмоос эхэлж хамуурдаг бөгөөд чих, толгой орчмыг хожгордуулан гэмтээх учир хуурай хамуу гэж ялгадаг. Маагуу бол гол төлөв өвөлжөөнөөс хойш илрэх бөгөөд анхны шинж тэмдэг нь малын бөгс хондлой орчмоор үс нь цантаж, мал тэр хэсгээ зууж маажлах зэргээр илэрнэ. Маагуурч буй хонь, үхрийг ялангуяа цас орсны маргааш хүйтэн өглөөгүүр нарны сөрөг харахад аль нэг хэсгийн үс нь цантсан нь мэдэгдэнэ. Мөн мал маагуурч буй биеийнхээ хэсгийг маажлах, зулгаах, долоох онцлогтой учир зарим хүн маагууг долоогуур гэдэг. Эмчлэх ардын олон арга чарга байдгаас цөөн хэдийг дурдъя. Тухайлбал, хоолны халбагаар нэг шарилжны үрийг 2 литр усанд хийж 1 литр болтол ширгээгээд хоолны жижиг халбагаар уулгана. Мөн адуу, тарвага, мануулын халуун тосыг хуурай хамуутай малд түрхэж эмчилдэг. Хамуу нь маш амархан халддаг төдийгүй мэдэгдэхгүй байсаар нэг малаас нөгөөд халдварлан газар авдаг онцлогтой өвчин юм. Иймээс сүрэг суурийн дотроос ганц нэгэн мал хамуурах шинж мэдэгдвэл бүх суурийг хамарсан арга хэмжээ авах нь илүү үр дүнтэй. Малын хашаа хэвтэр, тоног хэрэглэл, ус, бэлчээрийг ариутгах хэрэгтэй болдог. Иймд хамуу өвчний шинж тэмдэг илэрмэгц даруй малын эмч, мэргэжилтнүүдэд мэдэгдэж тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй.

■ ТУУРАЙН ГЭМТЭЛ:

Малын хар туурайн гэмтэл элбэг тохиолдох бөгөөд үүдэгдэн үүсэх шалтгаан олон байдаг. Дан элсэрхэг зөөлөн хөрстэй нутгийн малын туурай сунаж хэтэрхий урт ургах явдал мөн бий. Үүнийг хурц хутга хайчаар тэгшлэн тайрах, халуун төмрөөр хайрах зэргээр засаж байхгүй бол малын явдал гишгэлт өөрчлөгдөж улмаар судас шөрмөсний гэм тогтож болох муу талтай. Хатуу хөрстэй чийг багатай газрын малын туурай хавчих, хагарах явдал тохиолддог. Туурай хавчвал уг мал эхлээд балбагнаж, цөмцрөх ба их хавчвал гишгэж чадахгүй болдог. Голдуу адууны урд хөлийн туухай хавчих нь элбэг тохиолддог. Туурай хавчвал гахайг нь тойруулан цэвэрлээд хар турууны ёроолоос зохих хэмжээгээр зорон шулж аргалдаг. Тэрчлэн урд хөлний сиймхий судсыг хатгаж бага зэрэг цус авдаг. Малын туруу хагарвал хагархайн дээд үзүүрийг дайруулан хөндлөн хэрчлээс хийвэл цааш хагарахгүй аажимдаа ургасаар бүтэж эдгэрдэг.

Байнга байранд байсан буюу хатуу хөрсөнд бэлчдэг эсхүл үргэлж тагтай байсан туухайн гахай сунадаг гэм бий. Гахай нь сунасан морины гахайн эврийг эм эвэрт нь хүртэл хусаж зорох хэрэгтэй. Зөөлөн элсэрхэг хөрсний адууны туурайн гахайн завсраар элс чихэж гахай улддаг юм. Тийм үед элсийг нь цэвэрлэж адуу, тарваганы болон бусад тос түрхэж гахайг ургуулбал зохино. Хатуу хайр чулуутай газраар явбал цөмөрдөг. Ингэсэн мал зүгээр явж байснаа гэнэт ганц хоёрхон удаа доголчихоод удалгүй эрүүл мэт явдаг. Тэгсэн морины



туурайн улыг шалгаж гахайд нь шигдсэн чулуу, мод байвал цэвэрлэж, хайр чулуугүй хөрстэй бэлчээрт гаргавал зүгээр болно.



МАЛЫН НҮД ӨВДӨХ:

Малын нүдэнд бууц, элс шороо, үнс, ургамлын хог, үр, өт, эмгэг төрүүлэгч бактери орсноос нүдийг үрэвсүүлж өвчлүүлдэг. Хэтэрхий дулаан, салхивч муутай байранд ялангуяа хужир, эрдэс тэжээл дутагдсанаас хурга, ишигний нүд өвддөг.

Шинж тэмдэг: Малын нүд улайж нулимс нь гоожиж, нүднээс өтгөвтөр шар ногоон нуух цувна. Нуух их цувснаас нүдний дотор булан, түүнээс доош хэсгийн арьс нойтогнож үсэн бүрхүүл халцарч дайртдаг. Хүндэрвэл нүдэнд үүл цагаа тогтон, хараа муудна.

Засал: Өвчилсөн нүдийг цэвэр усаар угаах, нэрмэл ус, тарваганы тос, дөнгөж хургалсан хонины уураг сүү зэргийг дусааж эмчлэхээс гадна давс, хужир, эрдсийг тэжээлийн хамт өгөх замаар малын ерөнхий чалхыг сайжруулах арга хэмжээ авна. Нүд өвчилж цийсэн үед хар модны нүүрс, сахар хоёрыг тэнцүү хэмжээгээр сайтар нунтаглан хольж бага багаар өдөр өнжиж нүдэнд хийх, харин үүл цагаа нүдэнд тогтсон бол исгэлэн тараг, ёотон, давс нунтаглаж хийх, зэсийг нарийн хуурайгаар үрж гарсан үртэснээс нэг чимх авч нүдэнд хийхэд үүл арилдаг. Тарваганы тосыг цэврээр нь өдөрт 2 удаа 7-10 хоног хэрэглэхэд эдгэрэлт хурдан байдаг. Мөн чацарганы тосыг нүд улайх, нуухтаа, аргаж



хуурайших, цийх үед дусааж хэрэглэхэд сайн. Дээрх эмчилгээнээс гадна нүд улайх, хараа муудах, зовхи буух өвчний үед нүдний орчмын гурван судсыг ханаж цус гарган эмчилдэг.



■ НҮД НАЛХИТАХ:

Төл малын нүдний дотор өнцгийн аньсганаас мөгөөрсөрхөг хальс ургаж цагаан нүдийг хаахыг малчид “налхитах” гэж нэрлэдэг. Тэр хальсыг зүүнд сүвлэсэн утсаар сүвлэн татаж хайчилж авна.

■ ЭЛДЭВ ШАРХ ҮҮСЭХ:

Үзүүртэй төмөр, модонд сүлбүүлэх, мөргөлдөх, хазуулах, чоно, нохой урах, хачигтах, өтөх, хамуурснаас арьсаа маажиж, шалбалах зэрэг элдэв шалтгаанаар малын арьс, булчингийн эд шархална.

Шинж тэмдэг: Шарх үүсгэгдсэн шалтгаанаас хамаарч задгай болон битүү хэлбэрийн шарх үүснэ. Задгай шархнаас цус ихээр гоожихоос гадна урагдаж шалбарснаас болж арьс, булчингийн зарим хэсэг тасарч алга болсон, эсвэл үхэжсэн байж болно.

Засал: Шархыг эмчлэхийн тулд юуны өмнө цусыг тогтоох хэрэгтэй. Малчид хонь, тэмээний ноос, шар навтас, хөвөн зэргийн аль нэгийг шатааж нүүрсээр нь шархны өнгийг дарж цусыг тогтоодог. Хэрэв том судас гэмтсэнээс цус их алдаж байвал судасны дээд талаар сур, олсоор чанга боож хэсэг зуур байлган цусыг тогтсоны дараа авна. Шархыг эмчлэхэд далан түрүүний цэцэг, сэндэр,



алтан гагнуурын үндэс, гишүүний навч, үндэс зэргийг хандалж, шавшиж хэрэглэнэ. Гишүүн ба алтан гагнуурын үндсийг дотуур хэрэглэхэд шарх нь хурдан битүүрч эдгэрдэг. Удаан эдгэрэхгүй байгаа шархыг 200-250 гр хурдан цагааныг 1 литр усанд буцалгаж хандлаад 1 өдрийн завсартайгаар 1-3 удаа шавшиж угаахад сайн. Шархны шар (хурган засаа) ургамлын цэцэг, иш, навчийг авч хатаагаад нунтаглаж түүнээс 2 халбага авч литр усанд буцалгаж хандлаад шархыг шавших буюу бог малд 200-250 мл, бод малд 1 литр дотуур өгөхөд өвчин намдаж түргэн эдгэрнэ. Нарсны шилмүүс, боргоцойг сайтар буцалгаж хандлаад ямар ч малын шарх угаахад мах түргэн түрж ургахаас гадна ялаа суухгүй сайн талтай.

■ ДЭЛЭН АЙХ:

Малыг айхад дэлэн бүхэлдээ буюу ихэвчлэн нэг талын хэсэг нь чинэрэн хавдаж, халуун болсон байна. Энэ үед саалгахгүй, төлөө хөхүүлэхээс эмзэглэдэг.

Засал: Дэлэн өвчилж эхэлж байгаа үед дэлэнгийн урд талаас очсон хоёр судасны өвчилсөн талын судсыг дэлэнгээс 2-3 хуруу хиртэй зайд ханаж 100-200 мл цус авахад эдгэрнэ. Хэрэв 24 цаг болсон бол энэ эмчилгээ үр дүнгээ өгөхгүй. Түүнчлэн малын дэлэн айхад нууж авсан ихэр хүүхдийн оймс, хувцас, гуулин шанага, сангийн бойпор, бууны ам, гартаам хөөрөг, мөн ямар ч хамаагүй шанагыг ууранд халааж 2-3 удаа илж домнодог. Дэлэн нь айж, цочсон үед сэндэр шавж эмчлэх нь үр дүн сайтай байдаг.



